

БНМАУ-ААС БНСУ-ТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСОН НЬ, БНАСАУ-ЫН БАЙР СУУРЬ”

Д.Уламбаяр
ХИС-ийн ОУХНСС
Профессор, Доктор (Ph.D)

Рepublic of Korea буюу БНСУ-ыг (Өмнөд Солонгос) солонгос хэлнээ Тэ Хан Мин Гүг (대한민국, 大韓民國), харин монгол хэлнээ орчуулбал Их Хан Үндэстэн Улс хэмээх ажгуу. Олон улсын харилцаанд хоёр Солонгосыг ялгахын тулд газарзүйн нэр томъёогоор Хойд, Өмнөд Солонгос хэмээн голдуу нэрлэж заншсан бөлгөө. Democratic People’s Republic of Korea буюу БНАСАУ-ыг (Хойд Солонгос) солонгос хэлнээ Чусонь Минжүжүи Инмин Кунхуагүг (조선민주주의인민공화국, 朝鮮民主主義人民共和國), харин монгол хэлнээ орчуулбал Чусоны Ардчилсан Ардын Эвхамт Улс хэмээмүй. Тиймээс хойдуул нь урд талаа Өмнөд Чусонь, өмнөдүүл нь умард талаа Хойд Хангүг хэмээн нэрлэх ажээ.

Түүхэн хэлхээ холбоо

Монгол, Солонгос хоёр түүх, соёлын өнө эртний түүхэн уламжлалтай. Бүр 995 онд Хятан гүрэн Гуулин улстай соёлын харилцаа тогтоож, Гуулин улсаас 10 хүүхдийг түүх, хэл сургахаар Монгол нутагт илгээж байсан мэдээ Солонгосын сурвалж бичигт байгаа нь гадаад улсаас монгол угсаатны хэл, соёлыг албан ёсоор сургахаар төрийн бодлогын түвшинд арга хэмжээ авч байсан тухай хамгийн анхных нь мэдээ юм. Хоёр тал 1995 онд 1000 жилийн ойг нь өргөн дэлгэр тэмдэглэв.

Солонгосын хойгт оршин тогтнож байсан хамгийн эртний төрт улс нь Чусонь бөгөөд ХТӨ V-IV зуунд нэлээд хөгжсөн улс байжээ. Нийтийн тооллын эхний хэдэн зуун жилд Солонгосын хойг дээр Когурё, Пэкже, Шилла гэсэн эртний төрт улсууд үүсч оршин тогтнож байгаад X зууны эцсээр хойгийг бүхэлд нь нэгтгэсэн Корё улс байгуулагджээ. Энэ үеэс Солонгосыг Өрнө дахинд “Korea” хэмээн нэрлэсэн байх агаад харин Дорно дахины зарим улс түмэн “Гаоли” буюу “Гуулин” гэж дуудаж түүх сударт тэмдэглэжээ. “Монголын нууц товчоо”-нд гардаг “Солонгос” гэдэг үгийн гарлыг зарим судлаачид янз бүрээр тайлбарласан байдаг. Тухайлбал, монгол хэлний “солонго” гэдэг үгнээс үүсэлтэй гэх ба “ханбүк” хэмээх солонгос үндэсний хувцасны ханцуйг өнөө хэр солонгын өнгөөр ялган эмжиж хийсэн байдагтай холбодог байна. Өөрөөр тайлбарлах нь ч бас бий.

Хоёр орон өргөн дэлгэр харилцаатай байсан XIII зуунд Гуулин улсын гадаад харилцааны албанд ажиллах түшмэдээс монгол хэлний шалгалт авдаг байсан тухай Гуулин улсын дипломатын түүхэн сударт тэмдэглэжээ. Корёгийн үеийн хаад ноёд Юань гүрэнтэй худ ургийн холбоотой байсан ажээ. Тиймээс ч Монголын эзэнт гүрэнд эзлэгдсэн Алтан улс, Төв болон Дундад Азийн орнууд, Орос улс Чингис хаан, түүний дараах үе залгамжлагчдын хатуу хяналтад байсан бол Корё нь “хүргэн улс”-ын хувьд харьцангуй эрх дархтай, онцгой харилцаатай байжээ. “Монголын нууц товчоо”-г судлаач, доктор Б.Сумьяабаатар Чингис хааны алтан ургийн элэнц эх Алангуа нь “Кори” үндэстэн бөгөөд энэ бол “Корё” юм гэж нотолж байна. Юань гүрний сүүлчийн хаан Тогоонтөмөрийн эх ч Корё үндэстэн байсан гэж олонхи судлаачид үздэг. Юань гүрний Корёгоос аваачсан охид бүсгүйчүүдийн тоо 200 мянгаас давсан гэсэн эх сурвалж байх агаад тиймээс Монголчууд Солонгосыг “ээж улс” гэж нэрлэж байсан байж болох талтай.

Олон улсын харилцааны түүхэн дэх анхны эмэгтэй дипломат элчин монгол эмэгтэй байжээ. Энэ бол 1221 оны явдал буюу XIII зууны үе юм. «Монголын нууц товчоо» зохиогдсон 1240 оноос 20 жилийн өмнө «Чингис хааны элч 13 хүн Солонгост ирснээс нэг нь эмэгтэй хүн байлаа» гэж Солонгосын гадаад харилцааны түүхийн сурвалжид тэмдэглэснийг доктор Б.Сумьяабаатар өөрийн бүтээлдээ онцолсон байдаг. Монголчуудын соёлын түүхэнд холбогдох олон чухал мэдээ, баримт сайхь улсын түүхийн сурвалжид бий. 1221 онд Чингис хаанаас Солонгост илгээсэн өөр нэг зарлиг бичигт «Танайх бийр, бэх, бичгийн цаас зэрэг хэрэгсэл, гүргэм зэрэг эмийн ургамлыг илгээ» гэж өгүүлжээ. Тэгэхээр Монголчууд ямархуу соёлтой ард түмэн байсан нь мэдэгдэж байна. Зарим эрдэмтдийн бичсэнээр Монголыг хоёр хуваагаад Хятадтай хил залгаа байсан хэсэг нь бичиг үсэгтэй, Гурван голын буюу Чингисийн монголчууд бичиг үсэггүй байсан хэмээн бичдэг. Дээр дурдсан он Чингис их хаан ор сууж өргөмжлөгдөөд тун удаагүй, дэлхийн их гүрэн улсыг байгуулах арай болоогүй байхдаа ийн зарлиг бичиг илгээж байсан байна. Түүнчлэн 1283 онд Монгол жүжигчид Солонгост очиж тоглож байсан тухай баримт юм. Мөн «1218 онд Монгол цэрэг Солонгосын элч ирэхэд хөгжим үүсгээд наргиад сууж байлаа» гэсэн сонирхолтой мэдээ бас бий. Ер нь XIII-XIV зууны үеийн Солонгосын түүхэн сурвалжид Монголын тухай хаана ч байхгүй ховор нандин тэмдэглэлүүд үлджээ. Монголчуудын хууль цаазын бичгээс XIII зууны үеийн Чингис хааны «Их засаг» хуулийн бичмэл эх бүрнээрээ огт олдоогүй. Тэгвэл 2003 онд БНСУ-ын хуучин нийслэл Кёнжү хотын Сун овогтын хувийн цуглуулгаас хуулийн эмхтгэлийн тодорхойгүй байсан үлдсэн хэсэг олдсоныг доктор Б.Сумьяабаатар тайлбар, зүүлтийн хамт хоёр боть болгон Сөүл хотноо 2012 онд хэвлүүлжээ. ХХ

зууны эхээр Монголд хэвлэгдэж байсан зарим сонин, сэтгүүлд Чусонь улсыг “Өглөөний амгалангийн орон” гэж ханзных нь монгол орчуулгаар тэмдэглэж байв.

БНМАУ, БНСУ “Хүйтэн дайн”-ы үед

Монголчууд БНСУ-ын тухай анхлан 1950 оны 6 дугаар сарын 26-нд буюу Солонгосын дайн эхэлсэн өдрийн маргааш нь сонсож мэдсэн болов уу. Энэ мэдээг Ий Сын-маны фашист дэглэмтэй БНСУ-ын тоглоомын Засгийн газар, Америкийн империалистүүдтэй хамсан БНМАУ-ын дотны анд, ЗХУ-ын дараа дипломат харилцаа тогтоосон хоёрдахь улс БНАСАУ руу түрэмгийлэн довтолжээ хэмээн монголчууд хүлээн авсан нь түүхэн үнэн билээ. Солонгосын дайныг жинхэнэ өдөөн турхирагч, гол зохион байгуулагч нь Ким Ил-сон, Сталин, Мао Цзе-дун мөн болохыг 1990-ээд оны эхнээс социализм ноёрхож байсан орнууд мэдсэн юм.

БНМАУ Солонгосын дайнд БНАСАУ-ын талд баттай зогсож, эд материалын болон санаа сэтгэлийн үлэмж хэмжээний тусламж үзүүлжээ. Ерөнхий сайдын орлогчоор тэргүүлүүлсэн “Солонгосын ард түмэнд туслах хөдөлгөөнийг зохион байгуулах комисс” байгуулагдан ажиллаж, “Өмнөд Солонгосын тоглоомын дэглэм, Америкийн империалистүүд Солонгосоос бузар савраа тат”, “Солонгосын ард түмэн ялна” зэрэг лоозон дэвшүүлж, эсэргүүцлийн цуглаан болж байжээ. *Харин БНСУ-ын холбоотон Тайваны төлөөлөгчид НҮБ-ын индэр дээрээс Зөвлөлтийн дагуул БНМАУ нь түрэмгийлэн эзлэгч коммунист Умард Солонгост эд материалын тусламж үзүүлж, цэрэг шлгээснээр олон үндэстний энхийг сахиулах хүчний эсрэг тэмцэж, НҮБ-ын эсрэг зогсож байна. Иймд Сталины хүчээр Дундад улсаас булааж авсан нутаг дэвсгэр БНМАУ гэгч нь НҮБ-д гишүүнээр элсэх гавьяагүй юм гэж үзэж Монгол Улсын НҮБ-д гишүүнээр элсэхийг олон жилээр хойш нь татаж байв.*

Хоёр улстай холбоотой нэгэн үйл явдал олон улсын хэмжээнд болсон нь НҮБ-ын 1955 оны намрын чуулганаар БНМАУ, Японыг оролцуулан 18 улсыг нэгэн зэрэг универсиализмын зарчмаар НҮБ-д гишүүнээр элсүүлэх тухай Канадын саналыг Аюулгүйн Зөвлөл авч хэлэлцжээ. Энэ үед НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд Хятадыг төлөөлж байсан Тайвань 18 улсаас 11-ийг нь элсүүлэх, мөн үүн дээр БНСУ, Өмнөд Вьетнамыг шинээр нэмж оруулах саналыг гаргаж тавьжээ. ЗХУ БНСУ, Өмнөд Вьетнамыг хүлээн зөвшөөрч байгаагүй учраас энэ хоёр орныг НҮБ-д гишүүнээр элсүүлэх Тайванийн саналыг эсэргүүцэж, “хориг” тавьсан бөгөөд Тайвань ч аанай л Монгол, Япон хоёр дээр “хориг” тавих эрхээ эдэлсэн ажээ. Урьд нь БНМАУ ч 1949 оны 10 дугаар сард Хятадын Тайваньтай дипломат харилцаагаа тасалж, ардчилсан хувьсгалын дүнд шинээр байгуулагдсан

БНХАУ-тай дипломат харилцаа тогтоосон түүхтэй. Зөвлөлт-Дундадын хооронд байгуулсан холбоо, харилцааны тухай 1945 оны 8 дугаар сарын гэрээг 1953 оны 3 дугаар сард Тайванийн Засгийн газар мөн цуцалсан билээ. Энэ гэрээнд БНМАУ-ыг Дундад улсын Засгийн газар хүлээн зөвшөөрсөн заалт орсон байсан юм. Ийнхүү хүйтэн дайны үед их гүрнүүдийн сөргөлдөөний улмаас НҮБ-д БНМАУ, БНСУ хоёр гишүүнээр зэрэг элсэх асуудал тавигдаж, мөн зэрэг унаж байсан сонирхолтой түүхтэй ажээ.

БНСУ-аас Монгол Улсад сууж байсан анхны элчин сайд Квон Ён-сун хожим дурсан бичихдээ: 1961 оны 10 дугаар сард Нью-Йорк дахь БНСУ-ын Төлөөлөгчийн газарт ажиллаж байхдаа үндэсний баярын хүлээн авалт дээр дипломатуудын дунд нэгэн шуугиан дэгдсэн нь НҮБ-ын Төв байранд БНАСАУ-ын төлөөлөгчид үзэгдэх болсон тухай яриа гарчээ. Гэтэл тэд Хойд Солонгосчууд биш НҮБ-д шинээр элссэн Монголын төлөөлөгчид байсан ажээ. Тэдний царай зүс, төрх нь бидэнтэй үнэхээр адилхан байсан тул ийнхүү андуурсан юм. Түүнээс хойш Монгол Улс НҮБ-ын салбар олон байгууллагад ЗХУ-ын өмнөөс БНАСАУ-ын байр суурийг илэрхийлэх үүрэг гүйцэтгэж байв. Тухайн үед бидэнтэй харилцахдаа болгоомжлон цэрвэхээс өөр аргагүй байсан юм гэжээ. 1948 оноос НҮБ-ын дэргэд БНСУ-ын Байнгын ажиглагчийн статустай төлөөлөгчийн газар ажиллаж эхэлсэн юм. Харин БНАСАУ бүр хойно БНХАУ НҮБ-д эрхээ сэргээсний дараа 1974 оноос Байнгын ажиглагчийн газраа нээх боломжтой болсон ажгуу.

Үнэхээр 1961 оны 10 дугаар сард БНМАУ НҮБ-д гишүүнээр элсч, хууль ёсныхоо байр суурийг баттай эзэлсэн юм. Тухайн үед Хятадын Тайванийн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд төлөөлөх эрх нь хууль, эрхзүйн хувьд ноцтой хөндөгдөөд байсан үед арга буюу түүнчлэн Мавританийг дэмжихийн тулд Монголын төлөө санал хураалтад оролцоогүй юм. Ийнхүү НҮБ-д элсэх олон жилийн хүчин чармайлт амжилтанд хүрч, Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт 101 дэх гишүүн болсноор тус улсын тусгаар тогтнол олон этгээдээс баталгаажиж, Монгол орон тусгаарлагдмал байдлаас гарах, дэлхий дахинаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах боломжийг нээсэн билээ. Гэвч энэ боломжийг дүүрэн ашиглаагүйгээр зогсохгүй хүйтэн дайны улмаас НҮБ-ын индэр эсрэг тэсрэг хоёр системийн үзэл суртлын тэмцлийн талбар болж БНМАУ ч түүнд татагдан оролцож эхэлсэн юм.

БНМАУ нь БНАСАУ-тай найрсаг харилцаа тогтоон хөгжүүлж, энэ бүс нутагт энхтайвныг сахин бэхжүүлэхэд чиглэсэн Солонгосын Хөдөлмөрийн Нам, Засгийн газар, ард түмний хүчин чармайлтыг өндрөөр үнэлэн дэмжиж, “Өмнөд Солонгосоос Америкийн цэргийг нэн даруй зайлуулах, эх орноо энх тайван, ардчилсан замаар нэгтгэхийн төлөө шударга тэмцэл хийж буй ах

дүү Солонгосын ард түмний талд Монголын ард түмэн гуйвалтгүй зогссоор ирсэн, зогсох ч болно” гэсэн 1961 онд хуралдсан МАХН-ын ХГҮ их хурлын шийдвэрийг үндэслэн, БНАСАУ-ын үндэсний эрх ашгийг илэрхийлэн БНМАУ-ын төлөөлөгчид 1961 оны 12 дугаар сарын 7-нд Солонгосын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ХҮI чуулганд тогтоолын төсөл оруулж, түүнд Өмнөд Солонгосоос гадаадын цэргийг нэн даруй зайлуулахыг санал болгосон байна. Энэ бол БНМАУ НҮБ-д гишүүнээр элссэний дараа Монголын төлөөлөгчдөөс оруулсан анх удаагийн тогтоолын төсөл байв. Гэвч мөн үеэр чуулганд АНУ-ын оруулсан тогтоолын өөр нэг төсөлд Солонгосын асуудлыг хэлэлцэхдээ Солонгосын төлөөлөгчдийг оролцуулахгүйгээр үр ашигтай болж чадахгүй гэж буруушаан тэмдэглэсэн учраас дурдсан Монголын оруулсан тогтоолын төсөл батлагдаагүй байна.

Монголын төлөөлөгчид дээрх асуудлыг Ерөнхий Ассамблейн дараа дараагийн чуулганууд дээр үргэлжлүүлэн тавьсаар байсан юм. ХХII, ХХIII, ХХIV чуулган дээр БНМАУ-ын төлөөлөгчид Өмнөд Солонгосоос Америкийн болон бусад орны цэргийг гаргах явдал нь Солонгосыг энхтайвнаар сэргээн босгох зам дахь үндсэн саад тотгорыг арилгах юм гэдгийг мэдэгдээд НҮБ-ын далбаан дор Өмнөд Солонгосыг эзлэн авсан Америкийн болон гадаадын бусад орны бүх цэргийг гаргах тухай асуудлыг Ерөнхий Ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд социалист орнуудын хамт оруулж байжээ. Монголын төлөөлөгчид “Солонгосыг нэгтгэн сэргээх НҮБ-ын Комисс” гэгчийг тараахыг шаардаж байв.

Социалист орнууд биелэх боломжгүй янз бүрийн «энхтайванч» санал, санаачлагыг үзэл суртал, сурталчилгааны зорилготойгоор дэвшүүлэн тавих дуртай байсны жишээ нь 1981 онд хуралдсан МАХН-ын ХҮIII их хурлаас «Ази-Номхон далайн орнуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай» конвенци байгуулах “энхтайванч” санал дэвшүүлсэн нь амьдралд хэрэгжих улс төр, эдийн засаг, олон улсын харилцааны бодитой нөхцөл бүрдээгүй байсны улмаас хоосон лозунгийн шинж чанартай болсон юм. Түүнд Солонгосын хойгийн өмнөд хэсгээс Америкийн цэргийг гаргах, 1976 оноос жил болгон хийх болсон БНСУ, АНУ-ын цэргийн хамтарсан “Team Spirit” хээрийн сургуулийг бүрмөсөн зогсоох асуудал тусгагдаж байсан нь ойлгомжтой байв. Дээрх санал нь зөвхөн 1987 оны 7 дугаар сард Улаанбаатарт болсон Ази-Номхон далайн орнуудын коммунист, ажилчны намуудын зөвлөлдөх уулзалтаар хязгаарлагдсан байна. Үргэлжлүүлэн МАХН-ын ХIХ их хурлаас Цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулахад Азийн орнуудын улс төрийн нам, парламент, үйлдвэрчин, залуучууд, эмэгтэйчүүд зэрэг олон нийтийн янз бүрийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэж байгааг харгалзан

Азийн орнуудын өргөн олон нийтийн төлөөлөгчид оролцсон энх тайван, хамтын ажиллагааны төлөө нийт Азийн чуулга уулзалт хийх нь зүйтэй гэж үзэж байжээ.

Вашингтон-Токио-Сөүлийн гурвалжин

Вашингтон-Токио-Сөүлийн цэрэг-стратегийн гурвалсан холбоо буюу тэнхлэг хэмээх нэр томьёо 1970-80-аад оны заагт олон улсын харилцааны үг хэллэгт бодлогын шинжтэйгээр орж ирсэн юм. Ази дахь олон улсын хурцадмал байдлын үндсэн голомтын нэг нь Алс Дорнод, Номхон далайн бүс нутаг болж байв. АНУ-ын Засаг, захиргаанаас явуулж буй стратегийн бодлого нь энэ сав нутагт коммунизмыг тогтоон барихын тулд хүчний тэнцвэрийг найдвартай хадгалах, үүний тулд зэвсэглэлийн хувьд стратегийн зохих давуу байдал буй болгох үйл явцыг идэвхжүүлэх, Япон, БНСУ зэрэг түнш орнуудыг үүнд улам бүр идэвхтэй татан оролцуулахад оршиж байсан явдал юм. Харин 1983 оны 11 дүгээр сард АНУ-ын Ерөнхийлөгч Р. Рейганы Япон, БНСУ-д хийсэн айлчлал нь чухамхүү үнэн хэрэгтээ Зөвлөлтийн эсрэг Вашингтон-Токио-Сөүлийн “цэрэг-улс төрийн гурамсан холбоо”-г хэрэг дээр нь байгуулах зорилготой байсан гэж ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнууд үзсэн юм. Тиймээс ч Р.Рейганы айлчлалыг «доншуучлал» гэж нэрлэж байв. Рональд Рейганы Алс Дорнодын талаар явуулж буй бодлогод БНСУ нэлээд онцгой суурь эзлэх болов. АНУ Сөүлийн засаг захиргааг Алс Дорнод дахь өөрийн цэргийн оролцооны гол талбар хэвээр байлгахыг хичээж байсан юм. 1953 онд БНСУ-тай байгуулсан “Хамтын батлан хамгаалах гэрээ” нь тус улсыг эзэгнэхээ “хуульчлах” гэсэн оролдлого байсан гэхээсээ илүү Умардын аюулыг хазаарлан барихад чиглэгдсэн хэрэг байв. Хүчний тэнцвэрийг хадгалахад өмнөдөд байрласан Америкийн 37 мянган цэрэг, 1000 гаруй цөмийн нэгж чухал үүрэг гүйцэтгэж байсан ажээ. Ялангуяа 1983 оны 9 дүгээр сард ЗХУ-ын агаарын нисэх хүчин БНСУ-ын Иргэний агаарын тээврийн 007 дугаартай Boeing-747 онгоцыг байлдааны сөнөөгч онгоцноос пуужингаар харваж, 260 гаруй зорчигчдын амийг хөнөөсөн, 1983 оны 10 дугаар сард Бирмийн нийслэл Рангунд БНАСАУ-ын “хүндэт” удирдагч Ким Жон Илийн шууд оролцоотой удирдсан онгоцонд бөмбөг дэлбэлсэн террорист ажиллагааны уршигаар БНСУ-ын Засгийн газрын гишүүд болон өндөр албаны 17 тушаалтан амиа алдсан хэргүүдийг зөвтгөх ямар ч үндэслэл байхгүй байсан юм. Вашингтон Солонгосын хойгийг АНУ-ын «амин чухал эрх ашгийн бүс» гэж зарласан бөгөөд учир нь БНСУ бол АНУ-ын хувьд Дорнод Азийн эх газарт үлдсэн стратегийн цорын ганц түшиц газар байв. Р.Рейганыг Ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа АНУ-д айлчилсан хамгийн эхний зочин нь БНСУ-ын Ерөнхийлөгч Чонь Ду-Хвань байсан нь жирийн

хэрэг биш байв. Энэ айлчлалын эцэст 1981 оны 2 дугаар сарын 3-нд гаргасан хамтарсан мэдэгдэлд “Одоогийн Алс Дорнодын олон улсын нөхцөл байдал АНУ-ыг БНСУ-аас цэргээ гаргахгүй байхыг шаардаж байна” гэж онцлон дурджээ. Энэ чиг шугамыг Р.Рейган 1983 оны 11 дүгээр сард Сөүлд айлчлахдаа дахин нотолсон байна. АНУ-аас БНСУ-д үзүүлж байсан цэргийн тусламж 1982 онд 166 сая ам доллар байсан бол 1983 онд 210 сая болж өсчээ. 1976 оноос явуулж эхэлсэн АНУ-БНСУ-ын цэргийн хамтарсан “Team Spirit” хээрийн сургууль нь Умардын аюулыг тогтоон барих нэг арга хэрэгсэл гэж үзэж байв. Энэ хээрийн сургуульд анхнаас нь Японы өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчний штаб ажиглагчаар оролцож байсан бол сүүлийн үед цэргийн зарим анги, нэгтгэл оролцох хүртэл хэмжээнд хүрсэн нь Алс Дорнодод Вашингтон-Токио-Сөүлийн эвсэл бүрэлдэж буй болсныг харуулж байна гэж хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүд мэдээлэх болов. 1985 онд БНСУ-ын Ерөнхийлөгч Чонь Ду-Хвань Токиод, 1986 онд Я.Накасонэ Сөүлд айлчилж, хоёр тал олон асуудлаар санал нэгдэж, цаашид хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн ажээ. БНАСАУ-ын зүгээс гаргасан удаа дараагийн «энх тайванч» санал санаачилга нь улс төр, суртал ухуулгын шинж чанартай байжээ. Түүнчлэн БНСУ-аас дэвшүүлсэн нааштай санал санаачилгуудыг үл ойшоон тус орны усан болон агаарын хилийг зөрчих, цэрэггүй бүсэд будлиан үүсгэж, тус бүс нутгийн байдлыг хурцатгаж байсан нь ч үнэн юм.

Вашингтоны эрх баригчдын Азийн шинэ стратегид Япон улс онцгой байр эзэлж байв. АНУ Ясүхира Накасонэгийн Засгийн газрын өөрийгөө батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх, цэрэг, зэвсэглэлээр давуу байдалтай болох стратегийн бодлогодоо татан оролцуулахыг чармайж байв. 1985 оны эхээр АНУ-д хийсэн Японы Ерөнхий сайд Ясүхира Накасонэгийн айлчлалын үр дүн үүнийг батлан харуулав. Айлчлалын үеэр Я.Накасонэ 1985 онд өөрийн орны цэргийн зардлыг 6,9 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэнээ мэдэгджээ. Мөн “онцгой байдал” үүссэн нөхцөлд Япон, АНУ-ын цэргүүд байлдааны хамтарсан ажиллагаа явуулах тухай протоколд гарын үсэг зурсны гадна НАТО-гийн гишүүн Өрнөд Европын 5 оронд (ХБНГУ, Итали, Бельги, Нидерланд, Люсембург) дунд тусгалын (6 мянган км-ын тусгалтай буюу Уралын нуруу хүрнэ) “Першинг-2” болон “Томагавак” далавчит 576 пуужин байрлуулах АНУ-ын шийдвэрийг дэмжсэн юм. Номхон далайн умард хэсэгт болдог “Rimpark” цэргийн хээрийн сургууль нь Японы зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд ихээхэн түлхэц өгч, БНСУ-ын байлдааны хөлөг онгоцууд түүнд оролцож эхлэв. Түүнчлэн “Стратегийн батлан хамгаалах салбар дахь АНУ-ын санаачлагыг” ойлгож байгаагаа мэдэгдэж, судлаж үзэхээ амласан ажээ. Үүнийг Японд милитаризм сэргэж байна гэж социалист орнууд үзэж байв. Үнэхээр БНСУ болон Японы Ивакүни, Окинава

арал дээр АНУ-ын цөмийн цэнэгт хошуу, тэнгисийн цэргийн томоохон бааз байрлаж байв. Ер нь АНУ-ын байгуулахаар зорьж байсан “Номхон далайн хамтын нийгэмлэг”-т Япон, БНСУ-д онцгой үүрэг хүлээлгэхийг хичээж байсан юм.

БНМАУ-ын нам, төрийн удирдагч Ж.Батмөнх 1985 оны 6 дугаар сард Монгол-Болгарын найрамдлын цуглаан дээр хэлсэн үгэндээ: «АНУ Ази тивд байрлуулсан цэргийн хүчээ улам зузаатгаж, энэ тивийн өргөн уудам газар нутгийг цөмийн дайны талбар болгохоор санаархаж байна. АНУ Японы милитаризмыг сэргээх явдлыг элдвээр өөгшүүлж, Алс Дорнодод цэргийн томоохон эвслийн гол цөм болгох зорилгоор Япон, БНСУ-тай цэрэг-улс төрийн холбоо байгуулж байна» гэжээ. Тухайн үед БНМАУ-ын удирдлага өөрийн нутаг дэвсгэрт 120 мянган цэргийн бие бүрэлдэхүүнтэй, танкийн 3 дивиз, нисэх хүчний 1 дивиз бүхий хориглолтын бус, давшилтын зориулалттай Зөвлөлтийн цэргийн асар том бүлэглэлийг «өөрийн хүсэлтээр түр» байрлуулж байсан атлаа Япон, БНСУ-д байрлаж байсан АНУ-ын цэргийн баазыг тэндээс гаргахыг шаргуу шаардаж байв. Гэвч эдгээрийн аль аль нь цэрэг-стратегийн тэнцвэрийг хадгалах зорилготой байв. Японы эрх баригчдын “бүх нийтийн аюулгүй байдлын” систем байгуулах санаачлагыг Ази-Номхон далайн бүс нутагт цэрэг-улс төр, эдийн засгийн талаар Японы ноёрхолыг тогтоохыг зорьж байна гэж ЗХУ бусад социалист орнууд үзжээ. Олон улсын байдлыг хурцатгаж байсан гол буруутан нь коммунизм, капитализм хоёулаа байсан нь үнэн юм. Үнэндээ “Номхон далайн хамтын нийгэмлэг”-ийн үзэл санаа нь зөвхөн цэрэг-стратегийн зорилготой байгаагүй бөгөөд харин тус бүс нутгийн улс орнуудын хоорондын худалдаа-эдийн засгийн харилцаан дахь элдэв саад тотгорыг арилгаж, чөлөөт худалдааг хөгжүүлэх үндсэн дээр эдийн засгийн интеграцийг буй болгох явдалд өөр нэг үндсэн зорилго нь оршиж байсан юм. Хэрэг дээрээ Вашингтон-Токио-Сөүлийн гурвалжин нь цэрэг-стратегийн талаас гадна эдийн засаг, шинжлэх ухаан-техник, технологийн хөгжил нь хэлбэрэлтгүй өсөн нэмэгдэж байгаа Зүүн Азийн Япон, БНСУ-тай үүсээд байсан худалдааны санал зөрөлдөөнөө шийдвэрлэх нэг чухал механизм хэмээн АНУ үзэж байсан ажээ.

Стратегийн батлан хамгаалах салбар дахь АНУ-ын санаачилга

(Strategic Defense Initiative) Рональд Рейганы засаг захиргаа 1983 оны 3 дугаар сард “Стратегийн батлан хамгаалах санаачилга” (СБХС) төлөвлөгөөг албан ёсоор зарлав. 10 жилийн хугацаанд хийж дуусгах судалгаа, шинжилгээний хөтөлбөрт 60 тэрбум ам. доллар зарцуулахаар төлөвлөсөн тухай мэдээлэв. Хөтөлбөрийн гол зорилго нь эсрэг талын (ЗХУ-ын) хариу цохилт өгөх стратегийн баллистик пуушинг хөөрөх агшинд эсвэл нислэгийн даялалд нь

өөрийнх нь газар нутагт нь сансарт байрлах хиймэл дагуулаас лазерийн туяа ашиглан асар богино хугацаанд устгаж, АНУ-ын нутаг дэвсгэрийг хамгаалж чадах “сансрын бамбай” байгуулах зорилготой байсан ажээ. Энэ системийг бүтээхэд шинжлэх ухаан-техник, технологийн хамгийн сүүлийн үеийн ололтыг ашиглахад оршиж байв. ЗХУ үүнийг “Оддын дайны төлөвлөгөө” хэмээн нэрлэсэн юм. 1984 онд БХЯ-ны дэргэд “Стратегийн батлан хамгаалах санаачлагын байгууллага”-ыг тусгайлан байгуулжээ. Б.Клинтоны үед 1995 онд нэрийг нь өөрчлөн “Пуужингаас хамгаалах байгууллага”, Ж.Бушийн үед 2002 онд “Пуужингаас хамгаалах агентлаг” гэж өөрчлөгдөж байжээ. Япон улс шинжлэх ухаан-техникийн дэвшлийн олон чиглэлээр тэргүүлж байсан нь АНУ-ын сонирхлыг татаж байсан нь ойлгомжтой. “СБХС”-ыг зарласнаас хойш 1983 оны 11 дүгээр сард АНУ, Японы хооронд цэргийн технологийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зуржээ. Уг хэлэлцээрийн үндсэн дээр Америкийн Лос-Аламос дахь цөмийн шинжилгээний лаборатори Японы Осака их сургуулийн технологийн факультеттай лазерийн туяа судлах талаар хамран ажиллаж эхэлжээ. Японы эрдэмтэд нейтроны болон лазерын туяа судлах Ливерморын лабораторийн шинжилгээ, судалгааны ажилд мөн оролцох болсон байна. Үүнээс гадна Японы аж үйлдвэрийн хэд хэдэн томоохон корпорациуд СБХС-ын хүрээнд ажиллах гэрээнд гарын үсэг зуржээ. Японы Сайд нарын танхим СБХС-д оролцох болсноо 1986 оны 9 дүгээр сард албан ёсоор шийдвэрлэсэн байна. Ингэснээр “Toshiba”, “Matsushita Fujitsu”, “Hitachi” зэрэг 7 компани Америкийн энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд татагдан оржээ. Харин “Sony”, “Panasonic”, “Sanyo”, “Mitsubishi”, “Toyota” зэрэг цахим техник болон машины бусад үйлдвэр, корпорациуд сайхь төлөвлөгөөнд оролцохоос татгалзав. “СБХС-д оролцох нь пүүсүүдэд ямар ч ашиг өгөхгүй” гэж “Нихон кейзай” сонинд бичжээ. Дурдсан төсөлд оролцохоос татгалзаж байгаагаар 2000 нэрт физикч, 700 математикч, компьютерийн программ зохиогчид мэдэгдсэн байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлаас АНУ-ын цэрэг-аж үйлдвэрийн монополиуд л үлэмж ашиг олно гэж Японы зарим судлаачид үзэж байсан юм. “Цэргийн бараг бүх төрлийн технологийг нууцалсан болохоор Япон улс СБХС-д оролцсоноороо Америкийн технологийг төгс эзэмшинэ гэж бодох нь гэнэн хэрэг болно” гэж “Асахи шинбун” сонинд бичжээ. Японы парламентын гишүүн, нэрт эрдэмтэн Хүшими Кози “АНУ холбоотнуудаа хуурч мэхлээд СБХС-ын үр шимийг ганцаараа эзэмшихийг санаархаж байж болзошгүй. Үүний нэг жишээ нь “Manhattan” төслийг хэрэгжүүлсэн баримт юм. АНУ атомын бөмбөг бүтээх энэхүү төслийн эхний шатанд Англи, Францын эрдэмтдийг дайчилсан атлаа Хирошима, Нагасаки хотыг бөмбөгдөхөөсөө өмнө тэдний олонхийг ажлаас нь халж, зайлуулсан юм” гэжээ.

БНСУ 1986 оны 12 дугаар сард СБХС-д оролцож эхэлсэн бөгөөд албан ёсоор зарлаж байгаагүй юм. Тухайн үед Сөүлд хүрэлцэн ирсэн АНУ-ын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх, тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайдыг Засгийн газрын Ерөнхий сайд Но Шин-ен хүлээн авч уулзах үеэр энэ асуудлыг нарийвчлан хэлэлцжээ. Тусгай элч БНСУ-ыг АНУ-ын СБХС-д нэгдэхийг хүссэн Р.Рейганы хүсэлтийг Но Шин-енд дамжуулсан ажээ. Түүнээс хойш БНСУ-ын санхүү-аж үйлдвэрийн “Samsung”, “Daewoo”, “Lucky-Goldstar” зэрэг корпорациуд болон Ёнсей, Сөүлийн их сургуулийн технологийн институтийн судлаач эрдэмтэд хөтөлбөрт оролцох болжээ. Түүнчлэн Массачусетсын технологийн болон Беркли, Станфордын их сургуулийн солонгос гаралтай америкийн харьяат эрдэмтэн, судлаачид ч төслийн ажилд хамрагдсан байна. Солонгосчууд өгөгдөл боловсруулах, мэдрэгч цахим технологи, оптик, лазер, хэт ягаан туяа, гэрлийн онцлогийг (энерги, долгионы урт болон хурд) ашигласан технологийг эд ангиуд, машин механизмд суурилуулах, онгоцны хөдөлгүүрийг сайжруулах зэрэг чиглэлээр ажиллаж эхэлжээ.

АНУ-ын хамгийн ойрын холбоотон Их Британи 1985 оны 12 дугаар сард “харилцан ойлголцох тухай меморандум”-д гарын үсэг зурснаар СБХС-д татагдан орсон анхны орон болов. Их Британий тэр үеийн БХЯ-ны сайд М. Хейзлтад Английн компаниудад СБХС-ын хөтөлбөрөөр 1,5 тэрбум ам долларын ажил олгох баталгаа гаргаж өгөхийг хүссэн ажээ. “Британийн Засгийн газар СБХС-ын төсөлд нэмэлт хөрөнгө оруулахгүй, энэ хөтөлбөр Английн аж үйлдвэрийн эздэд ямарваа нэгэн үр дүн өгөх эсэх нь тодорхой харагдахгүй байна” гэжээ. Гэвч Английн “British Aerospace”, “Pilkington” зэрэг 9 компани оролцох болжээ. ХБНГУ 1986 оны 3 дугаар сард СБХС-ын дагуу хийх судалгаа шинжилгээнд ХБНГУ-ын пүүс, хүрээлэнгүүдийг татан оролцуулах тухай, технологийн солилцоо хийх тухай хэлэлцээрүүдэд гарын үсэг зуржээ. ХБНГУ-ын “Siemens”, “Rein metal” зэрэг 5 пүүс ойрын таван жилд 50 сая ам долларын ажил гүйцэтгэхээр гэрээ хийсэн байна. Итали 1986 оны 9 дүгээр сард АНУ-ын шинэ санаачилгад оролцохоор шийдвэрлэж, өөрийн пүүс компани, судалгааны хүрээлэнгүүддээ төсөлд оролцохыг нь зөвшөөрчээ. Италийн “Augusta”, “Airmark” зэрэг 9 компани 100 гаруй зүйлийг санал болгосон боловч 4 нь хэрэгжихээр болжээ. Израиль-АНУ-ын хооронд “харилцан ажиллах тухай меморандумд 1986 оны 5 дугаар сард гарын үсэг зурснаар Тель-Авив СБХС-д өргөн хүрээтэй оролцохоор болсон юм. Уг хэлэлцээрийг байгуулахаас өмнө Израиль сансрын цохилтын зэвсэг бүтээхэд ашиглаж болох технологийн 30 гаруй төслийн ажлыг Пентагонд шилжүүлсэн байна. Тель-Авив 1985 онд гэрээгээр 22 сая, 1986 онд 150 сая орчим долларын ажил гүйцэтгэснээс

гадна өөрсдийн хөрөнгө оруулалтаар үлэмж хэмжээний судалгааны ажил хийжээ. Израиль бол АНУ-ын цэрэг-аж үйлдвэрийн цогцолбортой хамгийн ойрын түнш болсон юм. Нидерланд, Бельги улсууд ч тодорхой төслүүд дээр ажиллах болжээ. ЕЭЗХН-ийн шинжлэх ухаан-техникийн “Europa” хөтөлбөр болон Европын сансрын судалгааны шинэ үеийн “Arian” пуужин, “Hermes”, “Columbus” загварын сансрын хөлөг бүтээх төслийг ч СБХС-д чиглүүлэхийг АНУ чармайж байсан ажээ. АНУ-д Засгийн газрын “NASA” агентлаг, цэрэг-аж үйлдвэрийн хамсал тэргүүлэн идэвхийлэн ажиллаж эхэлсэн юм.

Гэхдээ Америкийн олон зуун мянган эрдэмтэн, инженер-техникийн ажилтан, зохион бүтээгчид, түүний дотор Нобелийн шагналт 15 эрдэмтэн, Массачусетсийн технологийн их сургуулийн 100 гаруй профессор, багш нар СБХС-ыг эсэргүүцэж “СБХС-ын хөтөлбөр нь технологийн хувьд огт найдваргүй” гэж байжээ.

АНУ батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарыг сансрын уудамд дэлгэрүүлсэн нь олон арван тэрбум долларын өртөгтэй энэ хөтөлбөрт ЗХУ-ыг татан оруулснаар гол нь тус улсын эдийн засгийг туйлдуулан унагах, улмаар коммунизмыг буулгаж авах зорилготой байсан юм. Нөгөө талд 1986 онд АНУ-ын “Space shuttle” хөтөлбөрийн хүрээнд сансрын олон дахин ашиглах “Challenger” хөлөг хөөрөөд удалгүй сүйрч, 1987 онд ЗХУ-ын Чернобылийн атомын цахилгаан станц дэлбэрсэн зэрэг нь технологийн алдаанаас болж санамсаргүйгээр дэлхийн шинэ дайн гарч болзошгүйг хүн төрөлхтөнд нотлон сануулсан хэрэг болов.

БНМАУ “СБХС”-ыг ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн орнуудын адил шийдвэртэй эсэргүүцсэн юм.

Дипломат харилцаа тогтоохын өмнө

БНМАУ, БНСУ-ын харилцаанд холбогдох ойрх үеийн зарим нэгэн баримтаас дурдвал 1979 оны 8 дугаар сард хоёр орны хооронд спортын салбарт солилцооны үүд нээгдэж, Сонгомол барилдааны YI удаагийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо зохиогдоход БНСУ-ын 14 тамирчин Токио дахь Монгол Улсын ЭСЯ-наас баталгаат виз авч, улмаар Улаанбаатарт хүрэлцэн ирж амжилттай оролцжээ. 1980 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо зохиогдсон Чөлөөт бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд БНСУ-ын бүрэн бүрэлдэхүүнтэй баг тамирчид, сурвалжлах хэсгийнхэнтэйгээ оролцоход БНМАУ виз олгосон бөгөөд тэд нэр хүндтэй энэ тэмцээнээс мөнгө, хүрэл медал авч байжээ. 1983 оны намар Сөүлд болсон Олон улсын Парламентын бага хуралд Монголоос АИХ-ын депутат 3 төлөөлөгч анх удаа

оролцоход Токио дахь БНСУ-ын ЭСЯ виз олгож байжээ. 1987 оны 9 дүгээр сард Улаанбаатарт зохиогдсон Ази-Номхон далайн орнуудын парламентын олон улсын зөвлөлгөөнд БНСУ-ын Үндэсний Ассамблейн (парламент) хоёр гишүүн туслахын хамт оролцож байсан байна.

1988 оны Сөүлийн Олимп хоёр орны харилцаанд төдийгүй Өрнө-Дорнын харилцаанд нэн таатай уур амьсгалыг буй болгосон юм. БНСУ Сөүлийн Олимпоор өөрийгөө дэлхий дахинд нээн харуулж чадсан билээ. БНМАУ-аас БНСУ-д зохиогдох зуны ХХІҮ Олимпт оролцох зоримог шийдвэр нь мэдээж дангаараа, толгой мэдэж гаргасан шийдвэр биш байсан бөгөөд Куба улсаас бусад ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнууд Олон Улсын Олимпын Хороотой тохиролцон оролцохоор шийдвэрлэсэнтэй холбоотой байв. БНМАУ Сөүлийн Олимпт 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр амжилттай оролцож, боксын төрлөөр анх удаа Н.Энхбат олимпын хүрэл медаль хүртэж, Сөүлийн тэнгэрт БНМАУ-ын төрийн далбаа анх удаа мандсан юм.

Нөгөө талд Монголын төвийн хэвлэлүүдээр Азийн шинээр аж үйлдвэржсэн дөрвөн бар БНСУ, Тайвань, Хонг Конг, Сингапур болон Японы эдийн засгийн хөгжлийн гайхамшигийн тухай, БНХАУ дахь Дэн Сяопиний эдийн засгийн шинэчлэлийн бодлогын тухай бичих болсон явдал юм. “МОНЦАМЭ” агентлагийн “Мэдээлэл”, “Монгол пресс” агентлагийн “Цаг үе” товхимол албан ажлын хүрээнд зориулагдан дурдсан асуудлаар дэлгэрэнгүй материал орчуулан нийтлэх болов. Мэдээж Зөвлөлтийн хэвлэлүүдийг олон түмэн өргөнөөр захиалан уншиж байв. Өөрчлөн байгуулалт, улс төрийн шинэ сэтгэлгээ, ил тод байдлын нөлөөгөөр хэвлэл мэдээлийн хэрэгсэлүүд өнгөрсөн үеийн үндэсний хийгээд олон улсын харилцааны түүхийн цагаан толбо, Өрнө-Дорно дахинд болж буй үйл явдал болон асуудал дэвшүүлсэн, хурц, шинэ сонин содон мэдээ, мэдээллийг аль болохуйц хүртээмжтэйгээр хэвлэн нийтлэх болсон юм.

БНСУ дэлхийн тавцанд гарч ирсэн нь

БНСУ буюу Өмнөд Солонгос нь Солонгосын хойгийн 38 дугаар өргөргөөс өмнө этгээдэд орших 98,4 мянган кв. км газар нутагтай, өөрөөр хэлбэл Монгол Улсын нутаг дэвсгэрээс 15 дахин бага, 51,6 сая орчим хүн амтай (2016 оны байдлаар), нийслэл Сөүл нь 11 сая оршин суугчидтай, тус улс засаг захиргааны 9 муж, 5 томоохон хотоос бүрдэж байв.

1945 онд дэлхийн II дайн дууссаны дараа Солонгосын хойг хоёр хэсэгт хуваагдаж, гурван жилийн дараа 1948 оны 8 дугаар сарын 15-нд хойгийн өмнөд хэсэгт капиталист нийгэм-эдийн засгийн байгуулалтай БНСУ байгуулагдсан байна. 1987 онд ардчиллын төлөө өрнөсөн өргөн олны хөдөлгөөний үрээр

бүх нийтийн сонгууль явуулж, түүнд Шударга ёсны ардчилсан нам ялалт байгуулснаар тус намын дарга Но Тэ Ү Ерөнхийлөгчөөр сонгогдож, иргэний Засгийн газрыг байгуулжээ.

Солонгосын дайнд аж ахуй нь сүйдсэн, эдийн засгийн хөгжлөөр буурай, байгалийн баялгаар хомс байсан БНСУ өнгөрсөн хугацаанд үсрэнгүй хөгжиж, Ази-Номхон далайн бүс нутгийн төдийгүй дэлхийн эдийн засгийн харилцаанд тодорхой байр суурь эзэлсэн улс болон гарч иржээ. Сайхь улсын ДНБ-ний өсөлтийн хурдац жилд дундажаар 9-10 хувьд хүрч, 1962 онд нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 85 ам доллар байсан бол 1980-аад оны эцэст 5500 ам долларт хүрсэн байв. Өөрөөр хэлбэл, 28 жилийн дотор 50 дахин өсчээ. Экспортын хэмжээ 50 саяаас 60 тэрбум 700 сая ам доллар болж өсөв. Дэлхийн эдийн засгийн хөгжлийг хөтлөн чиглүүлж буй шилдэг 500 үндэстэн дамнасан корпорациудын 11 нь БНСУ-ын “Hyundai”, “Samsung”, “Daewoo”, “Lucky-Goldstar”, “Lotte”, “Hanjin”, “Kia”, “Ssangyong”, “SK”, “KAL”, “Asiana” зэрэг бизнес группүүд болж, тус орны гадаад худалдааны нийт эргэлт 115 тэрбум ам доллараар хэмжигдэж, дэлхийд 10 дугаар байранд орсон байв. Жижиг, дунд үйлдвэрлэл улс орны эдийн засаг, экспортын бодлого, гадаад худалдаа, өрхийн бизнест чухал үүрэг гүйцэтгэдэг байжээ. Made in Korea (Хойд Солонгос made in DPRK буюу Сделано в КНДР) шошигтой өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнээс эхлээд орчин үеийн эрэлт хэрэгцээтэй өнгөт телевизор, дүрс бичлэгийн тоглуулагч, хос хуурцагны стерео болон чихэвчний хөгжим, өнгөт фото болон дүрс бичлэгийн камер, тооцооны машин, электрон цаг, компьютер, гэр ахуйн болон албан ажлын цахилгаан хэрэгсэл болох хөргөгч угаалгын машин, будаа агшаагч, кофе буцалгагч, хувилагч машин, факсын аппарат түүнчлэн хөлөг онгоц, автомашин зэрэг нь дэлхийн зах зээлдээр өндөр үнэлэгдэх болж, шинжлэх ухаан-техник, технологийн тэргүүлэх салбарт үсрэнгүй дэвшил хийж АНУ, Япон, Өрнөд Европын орнуудтай өрсөлдөх түвшинд хүрсэн аж үйлдвэржсэн орон болсон байна. 1990 онд гэхэд 1,5 сая автомашин үйлдвэрлэхээр төлөвлөж, бичил, цахим бүтээгдэхүүн гадаадад экспортлох хэмжээгээрээ дэлхийд 3 дахь томоохон нийлүүлэгч болно хэмээн эдийн засагчид тооцоолж байжээ. Үүнийг ХХ зууны эдийн засгийн гайхамшигт үзэгдэл гэж нэрлэж байсан ажээ.

Эдийн засгийн давшингуй хөгжилтэй уялдан Ази-Номхон бүс нутагт явуулах БНСУ-ын бодлого идэвхижиж, бүс нутгийн хамтын ажиллагаанд бие даан оролцохыг эрмэлзэх болсон юм. Үүний нэг илрэл 1982 оноос эхлэн тус улс Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн үзэл санааг дэвшүүлэн тавьж идэвхитэй ажиллаж эхэлсэн явдал байв.

Өгүүлэн буй үед БНСУ дэлхийн 140 гаруй улс, түүний дотор Унгар, Польш, Югослав, Болгар, Чехословак зэрэг социалист улсуудтай дипломат

харилцаа тогтоосон байв. 101 оронд ЭСЯ, 36 консулын болон таван Байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан дипломат харилцаатай, харин БНАСАУ нь 100 гаруй оронтой дипломат харилцаатай байсан юм. 70 гаруй орон хоёулантай нь дипломат харилцаатай байжээ.

Мэдээж 1988 оны Сөүлийн зуны Олимпын тоглолтоор БНСУ нь өөрийгөө дэлхий дахинд бүрэн таниулж чадсан юм.

БНМАУ, БНСУ-ын худалдааны харилцааны оршил

1988 оны Олимпийн жилээс БНМАУ-БНСУ-ын хооронд худалдааны харилцааны эх суурь тавигджээ. БНМАУ-ын Гадаад худалдааны яамны дэргэдэх гадаад худалдааны “Монгол импекс” нэгдэл БНСУ-ын Засгийн газрын гадаад худалдааг дэмжих КОТРА агентлагийн Хонгконг дахь салбарын төлөөлөгчидтэй уулзжээ. Энэ уулзалтаар хоёр тал хэлэлцээ хийсний дүнд Хонгконгоор дамжуулан худалдаа хийхээр анхны гэрээг амжилттай байгуулсан байна.

БНСУ-аас БНМАУ ба Умардын орнуудтай хийсэн худалдаа

(сая доллар, хувь)

Улс		1988	1990	Хувийн өөрчлөлт
БНМАУ	Экспорт	0,140	0,515	267,4
	импорт	0,463	2,191	373,1
	Эргэлт	0,608	2,706	348,8
БНХАУ	Экспорт	1,438	1,553	8,0
	Импорт	1,705	2,268	33,0
	Эргэлт	3,143	3,821	21,6
ЗХУ	Экспорт	208	519	149,5
	Импорт	392	370	-5,6
	Эргэлт	600	889	48,2
Дорнод Европ ¹	Экспорт	270	541	100,4
	Импорт	117	213	82,1
	Эргэлт	387	754	94,8
Бусад орнууд ²	Экспорт	46	117	154,8
	Импорт	46	33	-22,8
	Эргэлт	92	150	63,0
Умардын бусад орнууд	Экспорт	1,962	2,731	39,0
	Импорт	2,261	2,886	27,6
	Эргэлт	4,223	5,67	33,0

Эх сурвалж: *Economic Planning Board, ROK, Economic bulletin. March. 1991*

1. Унгар, Польш, Югослав, Чехословак, Зүүн Герман, Болгар, Румын

2. Вьетнам, Лаос, Камбож

Гурав дахь орноор дамжуулж, нууцхан гэмээр байдалд хийсэн анхны худалдаагаар Монголын тал угаасан ноос, зэсийн баяжмал, төмрийн хаягдал зэрэг түүхий эд нийлүүлж, “Samsung electronics” компанийн хос хуурцагны стерео хөгжим, өнгөт телевизор, борооны хаалт, “Daewoo electronics” пүүсийн хөргөгч болон бусад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг 140 мянган ам. долларт багтааж хямд үнээр импортлож, Улсын их дэлгүүрийн «өндөр» үнийн тасгаар худалдаалсан нь хурдан борлогдсон байна. Харин монголчууд тэдгээрийг Хойд Солонгост үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн гэж ойлгосон нь үнэн юм. Сүүлд 1991 онд «Hyundai motors» компаний “Excel” загварын жижиг оврын суудлын автомашин 100 ширхэг болон амтархан идэх болсон «Choca Pie» анх удаа импортоор орж ирсэн нь монголчуудын дунд алдаршсан билээ.

БНАСАУ-ын байр суурь

1989 оны сүүлээр БНАСАУ-аас БНМАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ким Тэх-рюл “Үнэн” сонинд ярилцлага өгчээ. Тэрбээр хэлэхдээ: “Зарим социалист орон Өмнөд Солонгостой эдийн засаг, худалдааны харилцаа тогтоож байна. АНУ, Өмнөд Солонгосын эрх баригчид “Умардын дипломат ажиллагаа” явуулж социалист орнуудтай харилцаа тогтоох нь Солонгосыг нэгтгэх тэмцэлд саад учруулна гэж бид үздэг. Тиймээс социалист орнууд АНУ, Өмнөд Солонгосын эрх баригчдын “Хоёр Солонгос” бий болгох бодлого “Умардын дипломат ажиллагаа”-ны талаар сонор сэрэмжээ дээшлүүлэх хэрэгтэй. Бас Өмнөд Солонгостой ямар ч харилцаа тогтоохгүй байх хэрэгтэй. Манай хоёр хэсэг нэгдээд, Холбооны Бүгд Найрамдах улс байгуулсны дараа л харилцаа тогтоох хэрэгтэй гэж бид үзэж байна. Ах дүү Монгол нөхөд энэ талаар сонор сэрэмжтэй байж, бидний тэмцлийг ямагт дэмжихийг бид хүсч байна” гэхчилэн бүрэн эрхт улсын дотоод хэрэгт оролцон гадаад бодлогын талаар юу хийхийг зааварчлан, анхааруулга, сануулга өгч байв.

1990 оны 1 дүгээр сард БНАСАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-нд хэвлэлийн бага хурал болж, энэ үеэр тус улсад БНАСАУ-ын хэргийг түр хамаарагч Ий-хен сэтгүүлчдийн асуултад хариулсныг “Монгол пресс” агентлагийн “Цаг үе” мэдээллийн товхимолд хэвлэн нийтэлсэн юм. Зарим социалист орон Өмнөд Солонгосыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосныг Танай оронд хэрхэн үнэлж байна вэ? гэсэн сэтгүүлчийн асуултад тэрбээр хариулахдаа: “Зарим социалист орон эдийн засгийн өнөөгийн бэрхшээлээс гарах зорилгоор, бодит байдлыг хүлээн зөвшөөрөх үүднээс Өмнөд Солонгостой дипломат харилцаа тогтоолоо. Өөрөөр хэлбэл ийм хоёр шалтгаар холбоотон андаа хөсөрдүүллээ. Тэд ийм алхам хийснээрээ манай ард түмний эх орноо нэгтгэх үйлсэд саад учруулаад зогсохгүй, БНАСАУ болон тэдгээр орны харилцаанд муу нөлөө үзүүлж байна. Тэд дипломат харилцаа тогтоосноороо Өмнөд Солонгосын тоглоомын Засгийн газрын байр суурийг л бэхжүүлж байна. Тэд империалистуудаас тусламж хүсч, АНУ-ын гар хөл болсон, Америк, Японы дэмжлэггүйгээр оршин тогтнож чадахаа больсон Өмнөд Солонгосын тоглоомын этгээдүүдээс өчүүхэн долларын ашиг олно гэж горьдож байна. Ангийн байр суурь хамаагаа алдаж, бодит байдлыг зөвшөөрөхөөс аргагүй гэж байгаа бол тэднээс ийм асуулт асуумаар байна. Тэд “Азийн 4 барын” нэг Тайваньтай харилцах тухайд бодит байдлыг хүлээн зөвшөөрнө гэж яагаад ярихгүй байна вэ? Манай орныг жижиг гэж басамжилж доромжилж байгаа хэрэг үү?” гэж хариулсан юм.

Харамсалтай нь БНМАУ, Бүгд Найрамдах Солонгос Улсыг хүлээн зөвшөөрч албан ёсны харилцаа тогтоож чадахгүй байсны учир нь тухайн улсыг «дайсны

тал» гэж үзэж эсэргүүцэн сэргөлдөх социалист хамтын нөхөрлөлийн гадаад бодлогын нэгдмэл чиг шугамыг баримталж ирсэн учир БНСУ-ын тухай олон нийтэд буруу ташаа, нэн өрөөсгөл ойлголт төрүүлж байсан нь нууц биш юм.

Гол нь БНСУ-тай албан ёсны харилцаа тогтоохыг оршин амьдарч байсан нийгмийн тогтолцоо зөвшөөрөхгүй байснаар зогсохгүй, түнш БНАСАУ-ын зүгээс цаг үргэлж анхааруулан сануулж байсан хүсэлт, шаардлага ч томоохон хориг тээг болж байсан нь тодорхой.

Үүний зэрэгцээ аливаа асуудлаар санал санаачилга гарган хэрэгжүүлэхэд бодит байдлыг хичнээн зөв үнэлэн цэгнэж, хичнээн үнэмшилтэй баримт сэлтээр нотоллоо ч гэсэн өөрийн дотоод удирдлагын эрэмбэ шатыг гэтэлж, эцэслэн шийдвэрлэх эрх мэдэл бүхий дээд удирдлагын зарлиг зөвшөөрлийг олж авна гэдэг хамгийн төвөгтэй, хамгийн бэрх даваа байдгийг амьдралын туршлага илтгэн харуулам хэмээн ахмад дипломат Д.Ёндон гуай өгүүлсэн юм.

Дипломат харилцаа тогтоох БНМАУ-ын шийдвэр

Монголчууд “Цаг цагаараа байдаггүй, цахилдаг ногооноороо байдаггүй” гэж зүйрлэн хэлдэг нь аливаа юмс үзэгдэл ямагт нэгэн хэвээр байхгүй, улирах цагийн эрхээр өөрчлөгдөж шинэ хэлбэр агуулгатай болдгийг өгүүлэх агаад харин Солонгост “Арван жилд уул, ус ч өөрчлөгдөнө” гэсэн зүйр үг байдаг ажээ.

Гадаад, дотоод орчны өөрчлөлтийн үйл явцтай холбогдон 1980-аад оны сүүлчээс Монгол Улсад гадаад харилцааны салбарт томоохон дутагдал оршиж байгааг анх удаа хурц шүүмжилж эхлэв. Үүнд: нэгт, *Улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, хоёрт, гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах явдал хангалтгүй, гуравт, олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах ажил дутагдалтай, дөрөвт, гадаад үйл ажиллагаа голдуу тунхаглах, лозунгонох шинэстэй* байгааг шүүмжлээд үзэл суртал, бусад ялгааг шалтаг болгохгүйгээр өндөр хөгжилтэй Өрнө, Дорнын орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит байдалд нийцсэн олон улсын харилцааны ирээдүйтэй хандлага болсныг цохон тэмдэглэсэн юм.

Аанай л 1990 он гарахад олон улсын харилцаанд шинэ уур амьсгал, шинэ сэтгэлгээ улам бүр нэвтэрч, улс хоорондын харилцааны асуудалд үзэл суртлын ялгааны үүднээс ханддаг байсан урьдын зуршил өөрчлөгдөж халагдаж эхлээд байв.

Монгол Улс эдийн засгийн нээлттэй бодлого явуулах чиг шугамыг тунхаглан баримтлах болсон учир юуны өмнө бүс нутгийнхаа хөгжингүй орнууд, тухайлан хэлбэл БНСУ-тай худалдаа эдийн засгийн харилцаа тогтоон хөгжүүлэх нь Монгол Улсад ашигтай, газарзүйн хувьд ойр дөт, хялбар дөхөм байв. Тэрчлэн Монгол Улс Азийн хөгжлийн банк мэт бүс нутгийн зарим байгууллагад нэгдэн орж хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлж байсан учир тэдгээр байгууллагад идэвхтэй оролцогч БНСУ-ын дэмжлэгийг олж авах хэрэгтэй байлаа.

Монгол Улс бүс нутгийн улс орнуудтай яриа хэлэлцээ хийх талаар дэвшүүлсэн санал санаачлагаа хэрэгжүүлэх үүднээс БНСУ-тай нэгэн адил холбоо харилцаа тогтоож албаны хүмүүстэй нь уулзаж ярилцах шаардлагатай байв.

МАХН-ын ТХ-ны Ү бүгд хурлын гадаад бодлоготой холбоотой шийдвэрийг үндэслэн 1989 оны хавар БНМАУ-ын Засгийн газар “Ази-Номхон далайн хойд хэсгийн орнуудын хооронд байнга үйлчлэх яриа хэлцээний механизм” бий болгох санал дэвшүүлж, түүнд БНСУ ч хамрагдаж байсан юм.

БНМАУ-ын элчин сайд нар Япон зэрэг зарим оронд хэвлэлийн бага хурал, уулзалт зохиож улсынхаа гадаад бодлогын зорилт, байр суурийг тайлбарлан ярихад БНСУ-ын сурвалжлагчдаас “Монгол Улс бүс нутгийн асуудлаар манай улсад нэгэн адил хамаарагдах санал дэвшүүлсэн байна. Тиймээс та нар бидэнтэй уулзаж ярилцах уу?”, “Ер нь цаашид бүс нутгийн олон этгээдийн уулзалтад БНСУ-ыг хэрхэн оролцуулахаар бодож байна?” гэх мэт асуулт тавьж байсан нь бас нэгийг өгүүлж асан агаад БНСУ-тай харилцах талаар Монгол Улс юу бодож, ямар саналтай байгааг тандаж мэдэхийг эрмэлзэж байгаа нь тодорхой байв.

Харин Зүүн хойд Азийн бүсэд БНСУ-ыг хүлээн зөвшөөрч харилцаа тогтоогоогүй дөрвөн улс байсан нь ЗХУ, БНХАУ, БНАСАУ, БНМАУ байлаа. «Эдний хэн нь түрүүлж бидэнтэй гар барих бол. Эрх мэдэл, нэр нөлөөтэйгээрээ лав их гүрнүүдээс эхэлж санаачилга гаргах байх» хэмээн БНСУ хүсэн хүлээж байсан нь тодорхой.

Дээр өгүүлсэн бодит шаардлага, Монгол Улсын өмнө тулгарч байсан шинэ зорилтуудыг үндэслэн БНМАУ-ын ГЯЯ 1990 оны 1 дүгээр сард БНСУ-тай дипломат харилцаа тогтоох тухай санал боловсруулж, эхлээд яамны удирдлагын түвшинд нягтлан хэлэлцээд, саналынхаа үндэслэл нотолгоог дахин сайтар хянан үзэж, удирдах дээд байгууллагад төлнлуулахаар шийдвэрлэжээ.

Энэ тухай хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох хэлэлцээрт гар бие оролцож явсан ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, ахмад дипломатч Д.Ёндон дурсан өгүүлсэн юм.

БНСУ-тай дипломат харилцаа тогтоох асуудлыг тогтсон журмын дагуу МАХН-

ын ТХ-ны УТТ 1990 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаараа авч хэлэлцжээ. Хуралдааныг НТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх даргалж, УТТ-ны гишүүд, ТХ-ны нарийн бичгийн дарга нар ГЯЯ-ны сайд Ц. Гомбосүрэнгийн оруулсан саналыг олон талаас нь цэгнэн хэлэлцэж, хуралдаанд оролцогсод БНСУ-тай албан ёсны харилцаа тогтоох саналыг зарчмын хувьд зөвшөөрч, энэ чиглэлээр ажиллахыг ГЯЯ-нд даалгасан тогтоол гаргахаар болсон байна.

Нөгөөтэйгүүр харилцаа тогтоох саналаа БНСУ-ын талд мэдэгдсэний дараа ГЯЯ-ны сайдыг БНАСАУ-д очиж байр сууриа биечлэн танилцуулах нь зүйтэй гэж ярилцсан хэдий ч Ц.Гомбосүрэн сайд заавал Пёнъянд очих шаардлагагүй, Улаанбаатарт суугаа БНАСАУ-ын Элчин сайдад урьдчилан мэдээлж чиг шугамаа зөв ойлгуулахаар сайтар тайлбарлаж болох юм гэснээр уг асуудлыг хэлэлцэж дууссан ажээ.

БНСУ-тай дипломат харилцаа тогтоохыг БНАСАУ гарцаагүй эсэргүүцэж харамсал дургүйцлээ илэрхийлэх буюу өөр бусад алхам ч хийж болзошгүйг урдчилан мэдэж байсан учир тэднийд санаачилгаа үндэслэл нотолгоотойгоор тайлбарлаж, БНАСАУ-тай хойшид ч хэвийн сайн харилцаатай байхаа нотлон илэрхийлэхээр төлөвлөж байсан байна.

Тийнхүү БНСУ-тай харилцаа тогтоохоор дээд удирдлагын түвшинд хэлэлцүүлэн зөвшөөрүүлсэн нь үнэхээр ЗХУ-аас асуулгүй бие дааж толгой мэдэн хийсэн нэн чухал алхам байв хэмээн ахмад дипломатч Д.Ёндон өгүүлжээ. Харилцаа тогтоох санаачилгыг БНМАУ анхлан гаргасан бөгөөд тэр нь тухайн үедээ яах аргагүй зоримог алхам байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

БНСУ-ын шийдвэр

Дипломат харилцаа тогтоох шийдвэр гарсанаас хойш гурван долоо хоног гүйцэд өнгөрөөгүй байтал улс орны дотоод байдал улам ээдрээтэй болж нийгэм-улс төрийн амьдралд шинэ дуулиант үйл явдал гарсан нь эрх баригч МАХН-ын ТХ-ны ээлжит бүгд хурлаар намын онц их хурал хуралдуулах асуудал хэлэлцэх явцад ТХ-ны УТТ, Нарийн бичгийн дарга нар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцров.

Төр засгийн хамгийн дээд шатанд олон арван жил хөдлөшгүй бат оршиж тус улсын нийгмийн амьдралын бүх асуудлыг нэгд нэгэнгүй шийдвэрлэж ирсэн эрх баригч цорын ганц намын бүхнийг захирагч Улс Төрийн Товчоо тийнхүү нэгэн мөчид бүгдээрээ огцорсон нь урьд үзэгдэж сонсдоогүй үйл явдал болов.

МАХН-ын шинээр сонгогдсон УТТ-ны гишүүн, ТХ-ны нарийн бичгийн даргаар ГЯЯ-ны сайд Ц. Гомбосүрэн батлагдав.

1990 он 3 дугаар сарын 21-нд Ардын Их Хурлын чуулган эхэлж, Монголын

төр, засгийн тэргүүн нар өөрчлөгдөж, АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар П. Очирбат, Сайд нарын Зөвлөлийн даргаар Ш. Гунгаадорж нар сонгогдов.

Тэр хооронд төрийн алба, түүний дотор дипломат алба ч зохих журам ёсоор хэвийн үргэлжилж, идэвхтэй ажиллаж байжээ.

Алс Дорнодод улаан наран далайн мандлаас ургах Япон оронд хаврын улирал эхэлж, 3 дугаар сар дундаа орсон байлаа.

БНСУ-аас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд ноён Ий Вон-кюн Токио хотын төв хэсэгт орших Нью Отани зочид буудлын 15 дахь давхарт тусгай өрөө захиалан зэхэж, чухал асуудлаар ирж уулзах гэсэн Токио дахь Монгол Улсын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдыг хүлээж байв. Элчин сайд Б. Дашцэрэн тэрхүү 1990 оны 3 дугаар сарын 16-ны өдөр товлосон цагтаа хүрэлцэн ирж, төвөөс өгсөн удирдамж ёсоор БНМАУ-ын Засгийн газар Бүгд Найрамдах Солонгос Улстай албан ёсны дипломат харилцаа тогтоох хүсэлтэй байгааг уламжилж, дурдсан асуудлаар ноён элчин сайдтай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа мэдэгджээ.

Элчин сайд Б. Дашцэрэн цааш нь ярихдаа хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг эцэслэн шийдвэрлэх, холбогдох баримт бичиг тохиролцох, мөн худалдаа, эдийн засаг, соёлын салбарт хамтран ажиллах асуудал хэлэлцэхээр БНСУ-аас тусгай элч, төлөөлөгч ирүүлэх бол Монголын тал хүлээн авахад бэлэн байгааг мэдэгджээ. Монголын тал Солонгосын төлөөлөгчдийг 4 дүгээр сард хүлээн авч, харилцаа тогтоосон тухай мэдээг 5 дугаар сард нийтэд зарлахаар урьдчилан төлөвлөж байсан тул Б. Дашцэрэн эдгээр хугацааг уламжилж төвд боловсруулж хүргүүлсэн албан мэдээний төслийг гардуулжээ.

Элчин сайд Ий Вон-кюн нэн баярлууштай сайхан мэдээ сонслоо хэмээн талархаж, уг мэдээг Засгийн газартаа нэн даруй уламжилна гэжээ.

Азийн социалист орнуудаас чухам хэн нь түрүүлж тус улстай харилцаа тогтоох бол гэж БНСУ-ын дипломат албаны хүмүүс сонирхон хүлээж байсан нь лавтай. Харин БНМАУ эхэлж тийм зоримог алхам хийнэ гэж тэдний хэн нь ч үнэхээр бодоогүй байсан биз. Тиймээс ч элчин сайд Ий Вон-кюн төвтэйгээ холбоо яаралтай барьж мэдээлсэн зүйлийн хамгийн эхэнд «Бөмбөг тэс ондоо газраас өнхөрч ирлээ» гэсэн үг байсан нь найдан хүлээх, гайхан баярлах хоёрыг хослон илэрхийлсэн санаа мөн байсан болов уу хэмээн ахмад дипломатч Д.Ёндон бээр дурсан бичжээ.

БНСУ-ын тал БНМАУ-ын саналыг маш түргэн зөвшөөрч харнуг маргааш нь буюу ганц хоногийн дараа 3 дугаар сарын 17-нд өгчээ. Мөн баримт бичиг тохиролцох, хамтын ажиллагааны асуудал хэлэлцэхээр БНСУ-ын ГЯЯ-ны

парламентын асуудал эрхэлсэн дэд сайд тэргүүтэй төлөөлөгчдөө яаралтай томилон явуулахаар шийдвэрлэсэнээ мэдэгдэв.

БНМАУ БНСУ-тай дипломат харилцаа тогтоохоор санал болгосныг Ерөнхийлөгч Но Тэ-үүд өргөн мэдүүлсэн агаад Монголын санаачилга нь лав түүний бие даасан шийдвэр биш байх, харин ЗХУ харилцаа тогтоох боломж нөхцлийг тандаж, Монгол Улсаар эхлэн санал гаргуулж, дараа нь өөрсдөө харилцаа тогтоох гэж байгаа байх хэмээн ярилцаж байсан гэсэн яриа байдаг. Тиймээс БНСУ-ын тал ЗХУ гэдэг том гүрэнтэй харилцаа тогтоохыг эрхэмлэн БНМАУ-ын саналд яаралтай хариу өгсөн хэрэг хэмээн бодож байсан хүмүүс ч байсан ажээ.

Аль эсвэл Азийн социалист орнуудаас БНСУ-тай дипломат харилцаа тогтоох замыг БНМАУ нээж байгаа нь Дорнод Европын орнуудтай харилцаа тогтоож байгаагаас илүү чухал ач холбогдолтой гэж үзэж байсан байж болох талтай.

Юутай ч БНМАУ-ын дараа БНСУ-тай ЗХУ биш, Румын улс дипломат харилцаа тогтоосон түүхтэй.

Хоёр талын хэлэлцээ, дипломат харилцаа тогтоосон нь

БНСУ-тай дипломат харилцаа тогтоох саналыг тус улс нэгэнт зөвшөөрч төлөөлөгчөө ирүүлэх болсон учир манай талаас тийнхүү харилцаа тогтоохоор шийдсэнээ гурав дахь этгээд буюу БНАСАУ-ын Засгийн газрын сонорт албан ёсоор хүргэж, мэдэгдэх шаардлагатай болов.

Чингэхдээ БНСУ-ын ГЯЯ-ны төлөөлөгчийг хүлээн авч хэлэлцээ хийхээс өмнө мэдэгдэх нь зүйтэй байв. Учир нь хэлэлцээ хийж дипломат харилцаа тогтоосны дараа мэдэгдвэл БНМАУ БНАСАУ-тай найрамдлын гэрээтэй дотнын анд нөхөр мөртлөө түүний ар худрагаар “дайсан этгээдтэй” хуйвалдаж нууц хэлцэл хийв гэх мэтчилэн БНМАУ-ыг зэмлэн буруушаах сайхан шалтгаан болно гэж үзсэн хэрэг юм. Нөгөөтэйгүүр БНМАУ БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны дараа БНАСАУ-ын зүгээс элдэв эсэргүүцэл илэрхийлэх бол Монголын тал уг алхмыг хийхээсээ өмнө танайд байр сууриа албан ёсоор тайлбарлаж хэлж байсан гэж өчих бас нэг чухал нотолгоотой болох байсан ажээ.

Дээр өгүүлснийг үндэслэн 3 дугаар сарын 19-нд БНАСАУ-ын элчин сайд Ким Тэк-Рюлийг ГЯЯ-нд урьж БНМАУ БНСУ-тай дипломат харилцаа тогтоож элчин сайд нараа солилцон суулгахаар шийдвэрлэж байгаагаа итгэмжилсэн хэлбэрээр урьдчилан мэдээлж буйг Засгийн газартаа уламжилж өгөхийг хүсэв. Энэ шийдвэр бол аливаа асуудлыг сөргөлдөх аргаар бус, эв зүйгээр зохицуулах хандлага давамгайлж буй өнөө үед БНМАУ-ын тунхагласан эдийн засгийн нээлттэй бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа цаг үеэ олсон алхам юм хэмээн

харилцаа тогтоох гэж буй учир шалтгааныг тайлбарлан мэдэгдэв. Үүний зэрэгцээ БНМАУ БНАСАУ-тай найрамдалт харилцаагаа цаашид ч үргэлжлүүлэн хөгжүүлнэ гэдгийг нотлон илэрхийлж, элчин сайдад тайлбарласан зүйлээ төвд нь зөв уламжлуулахын тул санамж бичгийн хэлбэрээр гардуулж өгчээ.

Элчин сайд Ким Тэк-рюл хэлэхдээ: Өмнөд Солонгостой харилцаа тогтоох нь Солонгосын хуваагдмал байдлыг хэвээр байлгах оролдлогыг зөвшөөрөн дэмжиж байгаа хэрэг. Бид эх орноо нэгтгэж чадаагүйн гол шалтгаан бол Өмнөд Солонгост Америкийн цэрэг байгаа, мөн зарим хүчин хавсран оролцож байгаа явдал юм. Тиймээс харилцаа тогтоох нь тэдэнтэй гар хөлөө нийлүүлж байгаа хэрэг хэмээн тэр үеийнхээ үзэл суртлын хэвшмэл хэллэгээр ярив. Тэрээр өөрөө цочмогдон харамсаж байгаагаа хэлж, сонсгосон таагүй мэдээг төвдөө уламжлахаар явсан байна.

Түүнээс хойш дөрөв хоногийн дараа БНСУ-ын ГЯЯ-ны төлөөлөгчид хүрэлцэн ирснийг Монгол Улсын ГЯЯ-ны Азийн орнуудтай харилцах хэлтсийн дарга Ж.Чойнхор угтав. Төлөөлөгчид Улаанбаатарт хөл тавихын тулд 2-3 улсаар дамжин даруй 20 цаг нисч урт замыг туулжээ. Тэднийг ирсний маргааш нь амралтын өдөр байсан тул тэд алжаалаа тайлж, түүх дурсгалын газар, урлагийн тоглолт зэргийг үзэх боломжтой байв.

1990 оны 3 дугаар сарын 26-нд ГЯЯ-нд БНМАУ-БНСУ-ын хэлэлцээ эхэлж, БНСУ-ын ГЯЯ-ны дэд сайд Ий Ки-жу, түүнийг дагалдан ирсэн ГЯЯ-ны Зүүн хойд Азийн газрын дарга Ий Сун-жин, мөн яамны Эдийн засгийн газрын дарга Ий Юн-хөн нар оролцов.

БНМАУ-ын талаас ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д. Ёндон тэргүүлэн, Азийн орнуудын хэлтсийн дарга Ж.Чойнхор нар хэлэлцээ явуулав. Юуны өмнө улс орныхоо амьдрал байдал, түүний гадаад бодлогын чиг шугам, ялангуяа Азийн чиглэлд тавьж буй зорилт, гаргаж буй хүчин чармайлтын тухай зочиддоо тайлбарлан танилцуулсан байна. БНСУ-тай дипломат харилцаа тогтоох гол асуудлаар БНМАУ-ын талын гаргасан саналын утга учрыг дахин тайлбарлав. Мөн худалдаа, эдийн засаг, соёлын салбарт хамтран ажиллахыг үнэнхүү эрмэлзэж байгаа учраас Монголын холбогдох байгууллага, албаны хүмүүстэй тодорхой асуудал хэлэлцэж тохиролцох зорилгоор БНСУ-ын Засгийн газрын эдийн засгийн төлөөлөгчдийг урьж байгаагаа мэдэгдэв. Түүнчлэн БНМАУ-ын Азийн хөгжлийн банк, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүнээр элсэх хүсэлтэй байгаа зэрэг асуудлыг хөндөж ярьжээ.

Ийнхүү БНСУ-ын Засгийн газрын төлөөлөгчдийг урьж сонирхсон бусад асуудлаар мэдээлж тайлбарласан нь дипломат харилцаа тогтоохоор тохиролцох ердийн хэвшлийн хүрээнээс хальсан санаачилга байсан бөгөөд БНСУ-ын ГЯЯ-ны төлөөлөгчид ч БНМАУ-ын санал санаачилгыг дэмжих бэлтгэлтэй ирсэн байна.

Дэд сайд Ий Ки-жу хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоох талаар Монголын тал идэвх санаачилга гаргасныг талархан үнэлж, олон зуун жилээр тасарсан өвөг дээдсээс уламжлалтай хэлхээ холбоогоо сэргээж өдгөө хэвийн найрсаг харилцаа тогтоохыг Солонгосын ард түмэн, Засгийн газар онцгойлон үзэж сайшаан хүлээн авах болно гэв. БНМАУ-тай харилцан ашигтай байх, бие биеэ харилцан нөхөх үндсэн дээр хамтран ажиллах сонирхолтой байна. Бид танай оронтой эдийн засгийн туршлагаа хуваалцан, танайх манай улстай соёлын өв уламжлалын туршлагаа хуваалцаарай гэж Дэд сайд цохон тэмдэглэсэн байна. Тэрбээр ажил төрлийн хамтын ажиллагаанд шууд шилжихэд чиглэсэн хэд хэдэн тодорхой санал дэвшүүлэв. Тухайлбал хоёр улсын хооронд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагаа хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай зэрэг дөрвөн хэлэлцээрийн төслийг гардуулав. Тэрчлэн удирдлага техникийн салбарт хамтран ажиллах, мэргэжлийн боловсон хүчин сургах, дадлагажуулахад туслалцаа үзүүлэх, хоёр улсын эрдэм шинжилгээ, судлагааны зарим байгууллагын хооронд холбоо тогтоох зэрэг асуудлаар санал бодлоо илэрхийлэв.

Ий Ки Жу сайд Солонгос орны хөгжлийн эрч 1962 оноос эхэлж эдүгээ аль аль салбарт дэлхийн түвшинд хүрсэн тухай үнэмшилтэй баримт сэлтээр нотлон дэлгэрэнгүй ярьжээ. Тэрбээр Солонгосын үндэсний эвлэрлийн асуудлыг голлон дурдаж, тэр үед хурцаар яригдаж байсан хоёр Солонгос улсыг НҮБ-ын гишүүнээр элсүүлэх саналын тухай онцгойлон тайлбарлаж БНСУ-ын байр суурийг дэмжихийг хүссэн юм.

БНМАУ-БНСУ-ын анхны хэлэлцээгээр тийнхүү өргөн хүрээтэй асуудлаар санал, мэдээлэл солилцож эцэст нь хоёр орны хооронд элчин сайд нарын түвшинд дипломат харилцаа тогтоох тухай протокол байгуулахаар эцэслэн тохиролцсон байна.

Уг протоколд 3 дугаар сарын 26-нд хоёр улсын ГЯЯ-ны нэгдүгээр орлогч, дэд сайд нар гарын үсэг зурж гар барилцсан нь БНМАУ, БНСУ-ын хооронд албан ёсны дипломат харилцаа тогтоосон анхны мөч мөн бөлгөө.

Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосонтой холбогдуулан 26-ны үдэш ГЯЯ-нд зоог барих үеэр радио хүлээн авагч залгаж, БНМАУ БНСУ-тай харилцаа тогтоосон мэдээг Монголын радиогоор нэвтрүүлэхэд Дэд сайд Ий Ки Жуг нэрлэн дурдаж байгааг орчуулан сонсгоход зочдын сэтгэл нэн ханамжтай байжээ.

Дипломат харилцаа тогтоосны маргааш нь БНМАУ-ын “Үнэн” сонин, БНСУ-ын “Хангүг Ильбо”, “Чусонь Ильбо”, “The Korea Times”, “The Korea Herald” сонинд БНМАУ БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай албан

мэдээ Улаанбаатар, Сөүлд нэгэн зэрэг нийтлэгдэв. “Үнэн” сонинд “Уламжлалт харилцаагулам хөгжүүлнэ” гэсэн гарчигтай тэргүүн өгүүлэл нийтлэгджээ. Түүнд өгүүлэхэдээ: «Эдүгээ олон улсын харилцаанд шинэ сэтгэлгээ өргөн нэвтэрч, аливаа асуудлыг сөргөлдөөний аргаар бус, эв зүйгээр шийдвэрлэх хандлага давамгайлж байна. Манай улс гадаад харилцааны тодорхой асуудлуудыг улс төрийн шинэ сэтгэлгээний үүднээс эргэн харж, Ази тив болон бүс нутагт нэгэнт үүсэн бий болсон байдлыг бодитойгоор үнэлэн үзэж зүй зохистойгоор хандах шаардлагатай болж байгаа юм. Энэ бүхнийг үндэслэн БНМАУ Бүгд Найрамдах Солонгос Улстай (Өмнөд Солонгос) дипломат харилцаа тогтоохоор шийдвэрлэсэн бөгөөд энэ нь бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин бэхжүүлэх, эл нутгийн улс гүрний хооронд итгэлцэл, хамтын ажиллагааг зузаатгахад тус дөхөм болох юм. БНМАУ-ын Засгийн газар, Ази-Номхон далайн хойд хэсгийн орнуудын хооронд байнга үйлчлэх яриа хэлэлцээний механизм бий болгох талаар 1989 онд дэвшүүлсэн саналаа хэрэгжүүлэх талаар чармайлт тавьж байгаа бөгөөд БНСУ-тай дипломат харилцаа тогтоосон явдал уг саналыг ажил хэрэг болгох хүч чармайлтад тус дөхөм үзүүлэхсэн билээ. Мөн БНМАУ-ын эдийн засгийн өнөөгийн хөгжлийн бодит үйл явц, манай улсын тунхаглан хэрэгжүүлж байгаа эдийн засгийн нээлттэй бодлогын хүрээнд БНСУ-тай янз бүрийн салбарт харилцаа тогтоон хөгжүүлэх явдал цаг үеэ олсон асуудал болж байгаа юм. Шинээр аж үйлдвэржсэн орны нэг болох БНСУ-тай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үндэс суурийг тавьж, өргөжүүлэн хөгжүүлэх нь манай улсын өнөөдрийн гадаад эдийн засгийн харилцааны бодлогод бүрэн нийцэх нь дамжиггүй. БНМАУ, БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосон явдал, БНМАУ, БНАСАУ-ын найрамдалт харилцаа, олон талт хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд ямар нэг хэлбэрээр саад болохгүй юм. Манай улс БНАСАУ-тай тогтоосон уламжлалт харилцаагаа 1986 оны Найрамдал, хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр хойшид ч хэлбэрэлтгүй хөгжүүлэх болно. Улс орноо энхтайван замаар нэгтгэхийн төлөө солонгосын ард түмний явуулж байгаа тэмцлийг БНМАУ идэвхтэй дэмжих болно» гэжээ. Ийнхүү БНСУ-тай харилцаагаа хэвийн болгож, дипломат харилцаа тогтоосон 6 дахь социалист, харин Азийн анхны социалист орон болсон юм.

Сайд нарын Зөвлөлийн дарга Ш. Гунгаадорж “Чусонь ильбо”, “Seoul Daily” сонин, “МВС” телевизийн сурвалжлагчид ярилцлага өгсөн тухай 3 дугаар сарын 30-нд хоёр орны хэвлэлд гарав.

Тийнхүү харилцаа тогтоосон мэдээ мөдхөн түгж бусад улс орны сонорт хүрчээ. Хятадын Синьхуа агентлаг энэ тухай шуурхай мэдээлж, Японы сонин хэвлэлд «Азийн социалист орнуудаас Монгол Улс түрүүлж, Өмнөд Солонгостой

харилцаа тогтоов» гэж бичсэн байв. Мөн Улаанбаатарт суугаа дипломат төлөөлөгчийн газрууд харилцаа тогтоосон мэдээг олзуурхан хэлэлцэж «Монгол Улс Азийн Унгар болов» хэмээн Европын социалист орнуудаас Унгар улс түрүүлж Өмнөд Солонгостой харилцаа тогтоосонтой зүйрлэж байжээ. Харин ЗХУ хэмээх том гүрэн чив чимээгүй өнгөрөх шиг болсон нь Монгол Улс тэднийхээс түрүүлж харилцаа тогтоосонд эвгүйрхэж байсан болов уу гэж бид таамаглаж байсан гэж ахмад дипломат Д.Ёндон бичжээ.

БНАСАУ-ын эрх баригчид БНМАУ-ын хийсэн алхмыг эрс эсэргүүцсэн юм. 3 дугаар сарын 26-нд БНСУ-ын ГЯЯ-ны төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж эхлэх гэж байхад БНАСАУ-ын Элчин сайд ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайдтай яаралтай уулзана хэмээн ахин дахин шахаж шаардсаар байсан тул хэлэлцээгээ дуусгаж, харилцаа тогтоосон тухай баримт бичигт үсэг зурсны дараа уулзахад Засгийн газрынхаа даалгавраар хатуу ширүүн үг хэллэгтэй эсэргүүцлийн нот уншиж сонсгожээ. БНАСАУ-ын тал БНМАУ-ыг хэдхэн долларын төлөө дайсантай холбоо тогтоолоо хэмээн буруутгахыг оролдсон ажээ.

БНМАУ хэнтэй хэрхэн харилцах нь түүний бүрэн эрхийн хэрэг мөн болой. Үүний дагуу БНСУ-тай дипломат харилцаа тогтоох асуудлыг нэгэнт ярилцаж шийдвэрлэсэн. Энэ талаар эргэж буцах зүйл байж таарахгүй. Бид хэдэн долларын төлөө харилцаа тогтоох гэсэн юм биш. Тийм зорилгоор харилцаа тогтоох байсан бол дөчин хэдэн жил хүлээх шаардлагагүй байсан. БНСУ-тай харилцаа тогтоох явдал БНАСАУ-тай тогтоосон БНМАУ-ын харилцаанд нөлөөлөхгүй, хоёр орны харилцааны түвшин буурахгүй хуучин хэвээр байх болно гэж элчин сайдад хариу мэдэгдэв.

Дэд сайд Ий Ки Жу тэргүүтэй БНСУ-ын ГЯЯ-ны төлөөлөгчдийг тус оронд саатан зочлох үед ГЯЯ-ны сайд Ц. Гомбосүрэн, Сайд нарын Зөвлөлийн шинэ дарга Ш. Гунгаадорж, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П. Очирбат нар хүлээн авч найрсагаар ярилцжээ. Түүнээс гадна төлөөлөгчид Монголын төлөвлөлт, эдийн засаг, худалдаа, тээврийн асуудал эрхэлсэн байгууллагуудын удирдлагатай уулзаж, тэдгээр салбарт хамтран ажиллах боломж төлөвийн тухай санал солилцсон нь ашиг тустай болсон байна.

1990 оны 3 дугаар сарын 27-нд БНСУ-ын ГЯЯ-ны дэд сайд Ий Ки Жу Монгол пресс агентлагийн “Цаг үе” сэтгүүлд ярилцлага өгөв.

«Манай оронд хийж байгаа Таны айлчлалыг олон улсын харилцаанд гарч буй шинэ сэтгэлгээний нэг илрэл гэж үзэж байна?»

- Дэлхий дахинд хувьсгалт өөрчлөлт, шинэчлэлт болж байгааг бид мэдэж байна. Энэ өөрчлөлт нь дэлхий нийтэд энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, дэлхийн эдийн засгийг цаашид хөгжүүлэхэд чухал

ач холбогдолтой хэмээн үзэж байна. Миний ойлголтоор, Монгол орон энэ өөрчлөлт шинэчлэлтийн бараг эхэнд нь явж байгаа юм шиг надад санагдлаа. Би Монголын Засгийн газрын өндөр албан тушаалын хүмүүстэй уулзаж ярилцсан. Ярианы явцад Монголд өөрчлөлт шинэчлэлт эргэлт буцалтгүй болсон, үүнийг хийх нь зайлшгүй гэдгээ тэд сайтар ойлгон, зориг төгөлдөр, шийдэмгий байдлаар ажиллаж байгааг олж мэдлээ. Энэ үйл хэрэг амжилтад хүрнэ гэдэгт би итгэж байна.

- *Өнөөдөр дэлхий дахинд Азийн дөрвөн барын тухай их шуугих болжээ. Танай улс эдгээрийн нэг. Манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ямар бололцоо байна гэж та үзэж байна вэ?*
- Эдийн засгаа өнөөдрийн өндөр түвшинд хүртэл хөгжүүлэхийн тулд манай улсын иргэд маш их хүчин чармайлт тавьсан билээ. Бид энэ талаар багагүй туршлага хуримтлуулсан юм. Онцолж хэлэхэд, хүн сургах асуудал маш чухал байдаг. Манай хоёр орны хооронд нэгэнт дипломат харилцаа тогтоосон болохоор юуны өмнө бид хуримтлуулсан туршлагаа, ялангуяа хүн сургадаг аргаа монголчуудтай хуваалцаж, хөгжилд нь зохих хэмжээгээр тус дэмжлэг үзүүлнэ гэж бодож байна. Үүний зэрэгцээ эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны салбарт харилцан ашиг өгөх ямар чиглэл байгааг судлах нь чухал юм. Түүнчлэн харилцан ашигтай байж, бие биедээ тус дэм үзүүлэхийн тулд хөнгөн үйлдвэр, эрдэс, түүхийн эдийн салбарт хамтарч хөрөнгө оруулах асуудлыг судлах хэрэгтэй гэж үзэж байна. Гэхдээ манай эдийн засаг чөлөөт зах зээлийн системд тулгуурладаг учраас Засгийн газар бүх асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээлтэй байдгийг хэлэх хэрэгтэй. БНСУ-д дэлхийд нэрд гарсан томоохон пүүсүүд бий. Чухамдаа эдгээр пүүсээс Монголд хүн ирж хамтарч ажиллах бололцоог судалж байгаа юм.
- *Айчлалын үр дүн, ач холбогдлыг хэрхэн үнэлж байна вэ?*
- Бид анхны алхам хийж байна. Гадаад оронд айлчилж байгаа боловч ах дүү оронд ирсэн юм шиг ойр дотно санагдаж байна. БНСУ БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон нь Зүүн хойд Азийн районы амгалан тайван байдалд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо гэж үзэж байна. Энэ нь хоёр ард түмний ашиг тусын төлөө, нийт Азийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг урагш ахиулахад онцгой ач холбогдолтой үйл явдал боллоо гэж үзэж байна.
- *Манай хоёр үндэстэн эрт дээр үеэс харилцаатай явж ирсэн гэдэг?*
- Тиймээ. Монгол, Солонгос хоёр манай эриний өмнөх үеэс харилцаатай явж ирсэн. Бидний харилцаа нэг хэсэг тасраад дахин сэргэж байна» гэжээ.

Эдгээр уулзалт нь нэгэнт тогтоосон албан ёсны харилцаатай эрх тэгш хоёр улсын албаны хүмүүсийн анхны ажил хэрэгч яриа хэлэлцээ болсон юм.

Харин БНСУ-тай дипломат харилцаа тогтоох санаачилгыг Монгол Улс анхлан гаргасны хувьд тодорхой хэмжээний хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авах асуудлыг давхар хөндөж тавих ёстой байсан болов уу. Ийм боломжийг алдсан мэт санагддаг. Учир нь Дорнод Европын социалист орнууд, ЗХУ болон Вьетнам, БНХАУ нь чухамхүү хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийг дипломат харилцаа тогтоох асуудалтай зэрэгцүүлэн тавьсан бөгөөд тэгээд ч түүнийгээ авч чадсан юм.

Хоёр талдаа ЭСЯ-аа нээсэн нь

БНСУ-ын Засгийн газар 1990 оны 5 дугаар сарын эхээр БНМАУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар Квон Ён-суныг томилов. БНСУ-ын тал Улаанбаатарт ЭСЯ-аа мөн оны 6 дугаар сарын 18-нд “Улаанбаатар” зочид буудлын 3 дугаар давхарт албан ёсоор нээв. Анхны элчин сайд Квон Ён Сун сүүлд өөрийн дуртгалдаа бичихдээ: “... Миний бие Монгол улсад суух анхны элчин сайдаар томилогдож, 6 дугаар сарын 30-нд Монгол руу явсан. Одоо Сөүлээс 3 цаг гаруй нисээд Улаанбаатарт очиж болох авч тэр үед Солонгосчууд Хятадаар дамжин явах боломжгүй байсан тул Токио, Москва, Эрхүүгээр тойрч явахаас өөр аргагүй байв” гэжээ.

Тэрбээр Токиод очиж өөрийн улсын элчин сайд Ий Вон Кюны тусламжтайгаар БНМАУ-ын элчин сайд Б.Дашцэрэнтэй уулзан виз авч, Монгол орны байдлын талаар мэдээлэл сонсож материалтай болсон байна.

SAS компанийн онгоцоор Москвад очиж коммунизмын орон болох ЗХУ-ын улс төр, эдийн засаг, нийгмийн байдалтай танилцах боломж олджээ. Тэр үед ЗХУ-д сууж байсан КОТРА-гийн худалдааны төлөөлөгч Кон Ро Мений тусламжтайгаар Москвад суугаа БНМАУ-ын Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд, ноён Ц.Гүрбадамтай уулзаж хоёр орны харилцааны асуудлаар санал солилцсондоо олзуурхжээ. Элчин сайд, доктор Ц. Гүрбадам хэлэхдээ: “Монгол Улс Азийн орон боловч саяхан болтол нүүрээ баруун зүг рүү харуулсаар ирсэн. Одоо л жинхэнэ Азийн орон шиг БНСУ-тай дипломат харилцаа тогтоож байна” хэмээн ярьсан юм гэжээ.

Тэрбээр Улаанбаатар хотод 7 дугаар сарын 5-нд очиж дөрөв хоногийн дараа 7 дугаар сарын 9-нд Итгэмжлэх жуух бичгээ барьжээ. Ийм богинохон хугацаанд Итгэмжлэх жуух бичгээ барьсны дараа өдрөөс нь эхлэх Монголын үндэсний баярын арга хэмжээнд оролцох боломж гарсан ажээ. Итгэмжлэх жуух барих ёслол дууссаны дараа Ерөнхийлөгч П. Очирбаттай цаг гаруй ярилцахдаа

тэрбээр Ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа дипломат харилцаа тогтоосон анхны улс, шинээр эрчимтэй хөгжиж байгаа БНСУ-ын талаар сонирхон, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд их найдвар тавьж байгаагаа онцлон тэмдэглэж байв. Би байгалийн баялаг, хөрөнгө багатай Солонгос орон хурдан хугацаанд эдийн засгаа хөгжүүлэхийн тулд гадаадаас их зээл авсан болохоор Монгол Улсад санхүүгийн хувьд их хэмжээний тусламж үзүүлж чадахгүй юм гэхэд энэ хугацаанд эдийн засгаа хөгжүүлэхэд олсон туршлага, технологийн мэдлэгээ хуваалцаж, Монголын эдийн засгийг хөгжүүлэхэд чадлын хэрээр туслан хамтран ажиллах боломжтой гэдгээ нотлон хэлсэн юм. Ийнхүү Корё улс, Юань гүрний үед тасарсан хоёр орны харилцаа 600 гаруй жилийн дараа дипломат харилцаа тогтоосноор сэргэсэн юм. Холын худ ургаас ойрын садан төрөл болсон хоёр орны харилцаа улс төр, эдийн засаг, соёл, нийгэм зэрэг төрөл бүрийн салбарт түргэн хурдацтай хөгжиж байна гэж элчин сайд Квон Ён-сун хожим дурьсан бичжээ.

Дипломат харилцаа тогтоосны нэг жилийн ойн босгон дээр 1991 оны 2 дугаар сарын 1-нд БНМАУ-ын ЭСЯ Сөүлийн төвд орших үзэсгэлэнт Өмнөд уулын урд хормойд байрлах "Namsang village" хэмээх гадаадынхны амьдардаг 35 давхар орон сууцны 17 давхарт албан ёсоор нээгдэв. Нээлтийн ажиллагаанд БНСУ-ын ГЯЯ-ны дэд сайд болон дипломатууд, Солонгосын жижиг, дунд бизнесийн холбоо, Солонгос-Монголын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн Чой Со-мён, нийгэмлэгийн гишүүд, Дангүг их сургуулийн Ерөнхийлөгч Чань Чун Шиг, тус сургуулийн монгол хэлний зочин профессор, Б.Сумьяабаатар, БНСУ дахь анхны монгол аспирант, МУИС-ийн багш Д.Уламбаяр нар оролцов. Дангүг их сургуулийн Ерөнхийлөгч хувиасаа Монгол улсын ЭСЯ-нд «Hyundai motors» компаний шинэ загварын хар өнгийн «Sonata» суудлын автомашин, Солонгосын жижиг, дунд бизнесийн холбоо оффесийн тавилга бэлэглэв. Тангүк Их Сургуулийн Ерөнхийлөгч доктор, профессор Чан Чун-шик нь түүхч мэргэжилтэй бөгөөд Монголын дундад зууны үеийн түүхийг судалдаг нэгэн байв.

БНСУ дахь Монгол Улсын хэргийг түр хамаарагч Ж. Ломбо, худалдаа, эдийн засгийн зөвлөх Н.Содномцог нар ажилдаа оров. Тэд хоёул урьд нь Пёнян дахь БНМАУ-ын ЭСЯ-нд дипломат алба хашиж байсан юм. БНМАУ-аас БНСУ-д суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар тохоон томилогдсон П.Үржинлхүндэв бээр 3 дугаар сарын хууч дээр Ерөнхийлөгч Но Тэ Ү-д Итгэмжлэх жуух бичгээ барьснаар ажилдаа оров. Тэрбээр Ким Ил-соны нэрэмжит Пёняны их сургуулийн солонгос хэл, утга зохиолын анги, Москвад ЗХУ-ын ГЯЯ-ны Дипломатын академи дүүргэж, БНАСАУ дахь БНМАУ-ын ЭСЯ-нд атташегаас Элчин сайд хүртэлх албан тушаалд дэвшин ажиллаж

байжээ. Дипломат харилцаа тогтоосны нэг жилийн ойн үеэр БНМАУ-ын ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэн БНСУ-д албан ёсны найрсаг айлчлал хийж хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурсан билээ.

БНМАУ-аас шинээр аж үйлвэржсэн «Азийн бар» БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны дараа удалгүй БНМАУ-ын анхны бөгөөд сүүлчийн Ерөнхийлөгч П.Очирбат «Монгол улс ойрын 5-6 жилийн дараа “Азийн бар” орон болно» хэмээн сүр дуулиантай мэдэгдсэн юм.

Ашигласан бүтээл

1. Ulambayar D. «Mongolian-Korean relationship: Past and Present»-“The Historical and Cultural Relationship: 1000 Anniversary for International Conference. Korea Foundation, NUM, SFS, Ulaanbaatar.: Mongolia. June 1995
2. Сумьяабаатар Б. Монгол, Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд ШУА, УБ.: 1975
3. Ёндон Д. Гар барилцах замын эхэнд. «Монгол улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 10 жил». Баримт бичгийг эмхтгэсэн Ж.Ломбо. УБ.: 2000
4. Квон Ен-сунъ. БНСУ, Монгол улсын харилцаа-өнгөрсөн, эдүгээ, ирээдүй.«Монгол улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын харилцаа 10 жил». Баримт бичгийг эмхтгэсэн Ж.Ломбо. УБ.: 2000
5. Батмөнх Ж. Илтгэл, хэлсэн үг. УБ.: 1986
6. Ким Сү-ён. Монгол-Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв. «Дорно-Өрнө» сэтгүүл, ШУА, ОУСХ, 1991, №3 (26)
7. Уламбаяр Д. Өмнөд Солонгос XXI зууны Япон мөн үү. «Дорно-Өрнө» сэтгүүл, ШУА, ОУСХ, 1998. № 1,2, (42, 43)
8. Дипломатический словарь I, II, III томах, М.: 1984, 1985, 1986
9. Международные проблемы Азии 80-х годов. М.: 1983
10. Осипов А.А. Внешняя политика МНР. М.: 1963
11. Economic Bulletin. March 1991, Economic Planning Board, Seoul, POK
12. «The Korea Times». 26 march 1991
13. «Цаг үе». Монгол пресс агентлаг. УБ.: 1990, №1-10